



ШҮҮХИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

**СЭТГЭЛ САНААНЫ
ХОХИРОЛ, СЭТГЭЦЭД
УЧИРСАН ХОР УРШГИЙН
ТАЛААРХ СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ САН: ИХ/00/2023/04/14

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
2023.03.30

ТОВЬЁГ

УДИРТГАЛ.....	3
НЭГ. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ, СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШИГ ГЭХ ОЙЛГОЛТЫН АГУУЛГА	4
1.1. Монгол Улс	4
1.2. Бусад улс орнууд	5
ХОЁР. СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙН НӨХӨН ТӨЛБӨРИЙГ ТООЦОХ ТУХАЙ АРГАЧЛАЛЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....	7
2.1. Япон Улс.....	7
2.2. Бүгд Найрамдах Солонгос Улс.....	16
2.3. Бүгд Найрамдах Сингапур Улс.....	20
2.4. Оросын Холбооны Улс	23
ГУРАВ. ДҮГНЭЛТ	26
ЭХ СУРВАЛЖ.....	27

УДИРТГАЛ

Судлах зүйл

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 онд батлагдсантай холбоотойгоор холбогдох салбар хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн дагуу “сэтгэл санааны хохирол” болон “сэтгэцэд учирсан хор уршиг” гэх ойлголтын агуулга, түүний харилцаа, хамаарлыг нарийвчлан судлах хэрэгцээ, шаардлага үүссэн билээ.

Үүнтэй холбогдуулан Иргэний хуульд тусгагдсан “сэтгэл санааны хохирол”, Шүүх шинжилгээний тухай хуульд тусгагдсан “сэтгэцэд учирсан хор уршиг” гэх ойлголтуудын ялгаа зааг, сэтгэл санаанд учирсан хохирол, сэтгэцэд учирсан хор уршигийг бусад улсад ямар аргачлалаар хэрхэн тооцоолдог талаар дэлгэрүүлэн судлах болно.

Судалгааны хамрах хүрээ

Сэтгэл санааны хохирол, сэтгэцэд учирсан хор уршигийн талаарх судалгааг хийж гүйцэтгэхдээ Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс, Оросын Холбооны Улсыг сонгон авч судалсан болно. Улмаар тус улсуудын “сэтгэл санааны хохирол”-ын агуулга, сэтгэл санааны хохирол, сэтгэцэд учирсан хор уршигийг хэрхэн тооцоолж үнэлдэг талаар судлав.

Судалгааны бүтэц

Судалгааны ажил нь Удиртгал, Сэтгэл санааны хохирол, сэтгэцэд учирсан хор уршиг гэх ойлголтын агуулга, Сэтгэл санааны хохирол, сэтгэцэд учирсан хор уршигийн нөхөн төлбөрийг тооцох аргачлал, Дүгнэлт, Эх сурвалж гэсэн хэсгээс бүрдэнэ.

НЭГ. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ, СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШИГ ГЭХ ОЙЛГОЛТЫН АГУУЛГА

1.1. Монгол Улс

Сэтгэл санааны хохирол, сэтгэцэд учирсан хор уршиг гэх ойлголтууд нь Монгол Улсын хууль тогтоомжид ямар агуулгаар хэрхэн тусгагдсан талаар дүн шинжилгээ хийж үзвэл нэр томъёоны хувьд Иргэний хуульд “эдийн бус гэм хор”, “сэтгэцэд учирсан хор уршиг”, “сэтгэцэд учруулсан гэм хор”, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд “сэтгэцэд учирсан хор уршиг”, Шүүх шинжилгээний тухай хуульд “сэтгэцэд учирсан хор уршиг” гэх байдлаар тусгагджээ.

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд “сэтгэцийн эрүүл мэнд гэж хүн сэтгэцийн эмгэггүй байхын зэрэгцээ нийгэм болон хүрээлэн байгаа гадаад орчинтойгоо дасан зохицож хэвийн амьдрах, ажиллах, суралцах, нийгэмд зохих байр сууриа эзлэн хувь нэмрээ оруулж чадахуйц байдлыг” хэлнэ гэжээ. Хууль тогтоогчийн үзэл баримтлалыг авч үзвэл “сэтгэцэд учирсан хор уршиг” гэх нэр томъёог дээр дурдсан салбар хуулиудын суурь ойлголт болгон тогтоосон бөгөөд агуулгыг нь Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн тус тодорхойлолтоос хуулбарлан авсан байна¹.

Онолын судалгаануудын хүрээнд авч үзвэл, “гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол”², “сэтгэл санааны хохирол”³, “эдийн бус хохирол /сэтгэл санааны хохирол/”⁴ гэх нэр томъёонуудыг ямар нэгэн шүүлтүүргүйгээр ашигласан байдал ажиглагдаж байна.

Дээрх эх сурвалжуудын хүрээнд “эдийн бус хохирол” болон “сэтгэцэд учирсан хор уршиг” гэх нэр томъёонуудын харилцаа хамаарал харьцангуй тодорхой байх бөгөөд **“эдийн бус хохирол” буюу (non-economic or non-pecuniary loss)** гэдэгт “нэр төр” (Defamation), “хувь хүний нууц” (Privacy), сэтгэцэд учирсан хор уршиг зэрэг эдийн бус хохиролтой холбоотой бүхий л ойлголтууд багтаж байна. Үүнээс харвал **“сэтгэцэд учирсан хор уршиг” нь “эдийн бус хохирол”-ын тусгай төрөл юм.**

“Гэм хор”, “хохирол”, “хор уршиг”, “сэтгэц”, “сэтгэл санаа”, “сэтгэл санааны хямрал (emotional distress)”, зэрэг нэршлээр нь эдгээр ойлголтуудын агуулгыг илрүүлэх зорилгоор хууль зүйн тайлбар толь болон үгийн этимологийг ашиглан тайлбарлахыг оролдсон тохиолдол цөөнгүй байна. Гэвч дээрх ойлголтуудын агуулгыг эрх зүйн шинжлэх ухааны түвшинд тайлбарласан тайлбар, судалгаа шинжилгээ хараахан хийгдээгүй буюу “сэтгэцэд учирсан хор уршиг”, “сэтгэл санааны хохирол”, “сэтгэцэд учруулсан гэм хор”, “гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршиг” гэх ойлголтуудын агуулга хангалттай хэмжээнд судлагдаагүй (тодорхой болоогүй) байгаа үр дүн ажиглагдлаа.

¹ П.Сайнзориг, “Сэтгэцэд учирсан хор уршигийг нөхөн төлүүлэх эрх зүйн шийдэл /Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөл”, Эдийн бус хохирол ба сэтгэл санааны хохирол хэлэлцүүлэг, (2022 он).

² Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн, “Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцох аргачлал, гадаадын зарим улсын туршлага /Харьцуулсан судалгаа/”, Судалгааны тайлан, (2021 он).

³ А.Түвшинтөгс, Д.Ганхүрэл, Э.Золзаяа, “Сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх нэхэмжлэлтэй хэргийн хянан шийдвэрлэж буй шүүхийн практик, харьцуулсан дүн шинжилгээ”, ННФ Шүүхийн Шийдвэрийн Судалгаа №4, 15 тал (2022 он).

⁴ Б.Ариунзаяа, Л.Амгаланбаатар, Х.Норовсүрэн, “Эдийн бус хохирол нөхөн төлүүлэх тогтолцооны талаарх онолын асуудал ба Монгол Улсын шүүхээр эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж буй байдал”, ННФ Шүүхийн Шийдвэрийн Судалгаа №4, 94 тал (2022 он).

1.2. Бусад улс орнууд

Гадаад орнуудын сэтгэл санааны хохирлын тогтолцоо, гарал үүслийг судалбал манай улсын адил эдгээр ойлголтын агуулга, харилцан хамаарлын талаар нэг мөр, баталгаатай ойлголт өгөх судалгаа хомс байдаг. Энэ нь **сэтгэл санааны хохиролтой холбогдох ойлголтууд нь маш хийсвэр, субъектив шинжтэй** төдийгүй эрх зүйн тогтолцооны ялгаанаас шалтгаалан өөр өөр агуулгаар илрэх нь бий.

Иймд энэ талаар дагнан судалдаг харьцуулсан эрх зүйн судлаачид хүртэл нэгдсэн тодорхойлолт өгөхөөс цэрвэдэг байна. Гэвч эрх зүйн бүл үл хамааран хамгийн нийтлэг шинжээр нь авч үзвэл “сэтгэцэд учирсан хор уршиг” нь дараах өргөн болон явцуу утгаар илэрч байна:

а. Өргөн утгаар авч үзвэл “Сэтгэцэд учирсан хор уршиг” гэдэгт өвдөлт/зовуурь, шаналлын нөхөн төлбөрийг хамруулан ойлгодог (Pain and sufferings, Pretium Doloris, 慰謝料).

Англи-Саксоны эрх зүйд 19-р зуунаас эхлэн хүний бие махбодод гэмтэл учирснаас шалтгаалсан өвдөлт, шаналалд нөхөн төлбөр гаргуулах агуулгатай нэхэмжлэлийг хангаж эхэлсэн бөгөөд ийм нөхөн төлбөрийг нийтлэг байдлаар Pain and sufferings гэх нэр томъёогоор илэрхийлдэг⁵. Энэ төрлийн нөхөн төлбөр нь юун түрүүнд бие махбодод бодитоор мэдрэгдсэн өвдөлт, зовуурь шаналалд зориулж төлбөр олгохыг эн тэргүүний зорилгоо болгодог ба түүний дараагийн түвшинд гэмтлээс үүдэн хүн байхын утга учраа алдах (loss of dignity, moral injury), амьдралын баяр баясал үгүй болох (loss of enjoyment of life), хэвийн амьдрахад саад учрах (loss of amenities of life), нийгмийн байр сууриа алдах зэрэг тухайн гэмтлийн үр дагавар болох бүхий л эдийн бус хохирлын төрлүүдийг нөхөн төлөх явдлыг зорилгоо болгодог⁶.

Эх газрын эрх зүйн тогтолцоонд дундад зууны үед хүний бие махбодод гэмтэл учруулсан тохиолдолд, эрүүгийн хариуцлага ногдуулахаас гадна эрүүл мэндийн нөхөн төлбөр гэх шийтгэлийн шинжтэй мөнгөн хариуцлага ногдуулах болсон бөгөөд 19-р зууны эхэн үеэс Франц хэлний *dommage moral* буюу хүний оюун санааны оршихуйд учирсан хохирол, Латин хэлний *pretium doloris* буюу өвчин шаналал, уй гашуудлын үнэ цэнэ, Герман хэлний *Schmerzensgeld* зэрэг ойлголтуудаар өвчин, шаналлын хохирлыг илэрхийлэх болжээ⁷. Эдгээр ойлголтууд тухайн улс орны эрх зүйн соёл, түүхээс хамаараад ялимгүй ялгаатай утга болон бүтцийг агуулж байдаг боловч эцсийн дүндээ хүний оршихуйд учирсан хохирол эсхүл хүний бие махбодод бий болсон өвчин, зовуурь шаналлын нөхөн төлбөр гэх нийтлэг утгыг агуулдаг⁸. Энэ төрлийн хохиролд мэдээж өвчин зовуурь шаналлын нөхөн төлбөр (*pretium doloris*), хэвийн амьдрахад саад болох (loss of amenity), гоо зүйн хор уршиг (*aesthetic damage*), амьдрах хугацаа барцах (loss of life expectation), амьдралын баяр баясал үгүй болох (loss of enjoyment of life) зэрэг бүхий л эдийн бус хохирлын төрлүүд багтдаг.

⁵ Giovanni Comandè, *Towards a Global Model for Adjudicating Personal Injury Damages: Bridging Europe and the United States*, 19(2) TEMPLE INT'L & COMP. L. J. 241, 258-263 (2006).

⁶ Stephen D. Sugarman, *Tort Damages for Non-economic losses*, in COMPARATIVE TORT LAW 201, 201-203 (M. Bussani & A. Sebok eds., 2013); Ronen Avraham, *Estimating Pain and Suffering Damages*, in THE OXFORD HANDBOOK OF LAW AND ECONOMICS: VOLUME 2: PRIVATE AND COMMERCIAL LAW 97, 97-98 (Francesco Parisi eds., 2017).

⁷ Cees Van Dam, EUROPEAN TORT LAW 362 (OUP 2d ed. 2013).

⁸ Cees Van Dam, *supra* note 7, at 363; Ulrich Magnus, *Damages for Non-economic loss: German Developments in a Comparative Perspective*, 39(3) INT'L & COMP. LAW Q. 675, 678 (1990); Vernon Valentine Palmer, *Moral Damages: The French Awakening in the Nineteenth Century*, 36 Tul. Eur. & Civ. L. F. 45, 46 (2021).

Япон Улсад 慰謝料 буюу шууд хөрвүүлбэл “тайтгарлын нөхөн төлбөр” гэх утгатай ерөнхий ойлголт хэрэглэгддэг (精神的損害、無形損害、非財産的損害 гэх нэр томъёонууд ч мөн хэрэглэгддэг). 19-р зууны сүүл үед хууль тогтоогчийн зүгээс 慰謝料 буюу “тайтгарлын нөхөн төлбөр”-ийг “нулимсны мөнгө” (ナミだ金、涙金) гэж томъёолсон бөгөөд хүний уй гашуу, өвдөлт, зовуурь шаналлыг нөхөн төлөхийг зорилгоо болгосон нөхөн төлбөр гэж тайлбарлажээ⁹. Японы судлаачид “тайтгарлын нөхөн төлбөр” гэх ойлголтын агуулгыг тайлбарлахыг оролддоггүй бөгөөд энэ салбарын ихэнх судалгаа тус төлбөрийг хэрхэн шийдвэрлэж, тооцох тухай асуудалд төвлөрдөг ч энэ салбарын тэргүүлэх судлаач дараах тайлбарыг хийсэн байдаг¹⁰.

Хүний оршихуйд үнэ цэн гэж бий. Хүний оршихуйн үнэ цэн ямарваа нэгэн хууль бус үйлдлийн улмаас хохирсон тохиолдолд, түүнийг буцаан сэргээх эрх зүйн туслалцаа, арга хэрэгслийг “тайтгарлын нөхөн төлбөр” гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл “тайтгарлын нөхөн төлбөр” гэдэг нь өвчин, зовуурь шаналлын нөхөн төлбөр бөгөөд хохирогчийн эрхийн мэдрэмж, шударга ёсны мэдрэмжийг сэргээх зорилготой тогтолцоо юм¹¹.

Үүнээс үзвэл “тайтгарлын нөхөн төлбөр” нь агуулгаараа эдийн бус хохирлыг бүхэлд нь хамарсан маш өргөн хүрээтэй ойлголт юм.

b. Явцуу утгаар авч үзвэл “Сэтгэцэд учирсан хор уршиг” гэдэгт цэвэр сэтгэлийн шаналлыг ойлгодог (Emotional distress, Mental anguish, Pure emotional harm).

Эрх зүйн хөгжлийн хувьд дээрх цэвэр сэтгэлийн шаналал (emotional distress) нь өвдөлт/зовуурь, шаналлын нөхөн төлбөр (pain and suffering damages)-өөс урган гарсан хэдий ч, түүнийг нөхөн төлөх урьдчилсан нөхцөл болон шалгуур нь харьцангуй хатуу буюу өндөр байдаг.

Дээр дурдсанчлан өвдөлт/зовуурь, шаналлын нөхөн төлбөр (pain and sufferings) нь хүний оршихуйн үнэ цэн, тэр дундаа өвчин зовлонгүй байх буюу эрүүл мэндийг хамгаалах явдлыг зорилгоо болгодог гэж дүгнэж болох бол цэвэр сэтгэлийн шаналлын нөхөн төлбөр нь хүний “сэтгэцийн эрүүл мэнд” (mental health)-ийг хамгаалахад чиглэдэг¹².

Мөн өвдөлт/зовуурь шаналлын нөхөн төлбөр (pain and sufferings) нь хүний бие махбодод бодит гэмтэл учирсан тохиолдолд хатуу шалгуургүйгээр нөхөн төлөгддөг бол, цэвэр сэтгэлийн шаналлын нөхөн төлбөр (emotional distress) нь гагцхүү анагаах ухаанд хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчин, сэтгэцийн эмгэгтэй болсон тохиолдолд л нөхөн төлөгддөг¹³.

Өөрөөр хэлбэл цэвэр сэтгэлийн шаналлын нөхөн төлбөр (emotional distress) нь тухайн хүн өөрийн бие махбодод бодитоор хохирол амсаагүй, гол төлөв сэтгэл мэдрэлдээ хохирол амссан тохиолдлуудыг хамардаг гэж хэлж болно. Жишээ нь өөрийн биеэр осолд ороогүй хэдий ч осолд орсон хүнийг харсны улмаас сэтгэлийн шаналлыг амссан бол холбогдох нөхөн төлбөрийг буруутай этгээдээс гаргуулж болно. Тиймээс бие махбод бодитоор гэмтээгүй этгээдүүд цэвэр сэтгэлийн шаналлын нөхөн төлбөрийг авахын тулд

⁹ 住田守道「我が国の慰謝料論の軌跡と課題：人身損害賠償を中心に」大阪市立大学法学雑誌 66 巻 1-2 号 168 頁、172 頁参照（2020 年）。

¹⁰ 斎藤修「総論」斎藤修編「慰謝料算定の理論」2 頁（ぎょうせい 2010 年）。

¹¹ 斎藤修「慰謝料の現代的課題」私法 74 号 156 頁、157-158 頁参照（2012 年）。

¹² Cees Van Dam, *supra* note 7, at 174.

¹³ Giovanni Comandè, *supra* note 5, at 261.

шүүхэд хэт их хуурамч нэхэмжлэл (fraudulent claims) гарах вий гэх нийтлэг асуудал улс орон бүрд тулгардаг байна.

Франц Улсад “дотно сэтгэлийн хохирол” (affection injury) гэх ойлголтын хүрээнд өөрийн гэр бүл, ойр дотно хүний бодит хохирлоос шалтгаалан цэвэр сэтгэл мэдрэлийн шаналал амссан этгээд нөхөн төлбөр авах боломжтой¹⁴.

Герман Улсад цэвэр сэтгэл мэдрэлийн шаналлын нөхөн төлбөрийг тухайн хохирогчийн зөвхөн гэр бүлийн гишүүн, ойрын хамаатан садан анагаах ухаанд хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчнийг тодорхой хугацааны турш туссан тохиолдолд авах боломжтой¹⁵.

Англи Улсын тогтсон шүүхийн жишгийн хүрээнд, цэвэр сэтгэл мэдрэлийн шаналлын нөхөн төлбөрийг авахын тулд, 1) сэтгэцийн өвчинтэй болсон 2) ойрын харилцаанд байсан (proximate relationship) 3) орон зай, цаг хугацааны ойрын хамааралтай байсан (proximity in time and space) 4) сэтгэл мэдрэлийн шаналал нь гэнэтийн шокоос бий болсон 5) хариуцагч хүний сэтгэл мэдрэлд шок бий болно гэдгийг урьдчилан харах боломжтой байх гэх урьдчилсан нөхцөлүүдийг хангах шаардлагатай болдог¹⁶.

Түүнчлэн цэвэр сэтгэл мэдрэлийн шаналал нь бодит хохиролтой холбоогүй субъектив шинжийг түлхүү агуулж байдаг тул түүнийг тогтооход анагаах ухааны мэргэжлийн шинжилгээ чухал үүргийг гүйцэтгэдэг. Энгийнээр хэлбэл хүн бусдад зодуулсны улмаас гараа тайруулсан тохиолдолд түүнээс өвчин зовуурь шаналал бий болно гэдэг хэнд ч ойлгомжтой. Гэтэл машины ослыг харсны улмаас сэтгэл мэдрэлийн шаналал амссан гэж үзэх тохиолдолд тухайн хүнийг сэтгэл мэдрэлийн ямар шаналал амсаж байгааг хүн гаднаас нь хараад мэдэх боломжгүй бөгөөд сэтгэл мэдрэлийн шинжилгээ зайлшгүй шаардлагатай юм.

ХОЁР. СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙН НӨХӨН ТӨЛБӨРИЙГ ТООЦОХ ТУХАЙ АРГАЧЛАЛЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

2.1. Япон Улс

1. Оршил

Япон Улсын Иргэний хуулийн 710 дугаар зүйл “Тайтгарлын нөхөн төлбөр”¹⁷-ийн үндэслэлийг дараах байдлаар тусгаж өгсөн.

Бусдын бие махбод, эрх чөлөө болон алдар хүндэд гэм хор учруулсан тохиолдол болон бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан аль ч тохиолдолд 709 дүгээр зүйлд заасны дагуу хохирлыг хариуцах үүрэгтэй этгээд нь эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

Иргэний хуулийг батлах үед, “Тайтгарлын нөхөн төлбөр”-ийг хэрхэн тогтоох вэ гэдэг дээр маргаан өрнөсөн ч хууль тогтоогч болон судлаачид санал нэгтгэйгээр “Тайтгарлын нөхөн

¹⁴ Cees Van Dam, *supra* note 7, at 176.

¹⁵ Cees Van Dam, *supra* note 7, at 176.

¹⁶ Cees Van Dam, *supra* note, at 180.

¹⁷ Япон Улсад сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийг нийтлэг байдлаар “Тайтгарлын нөхөн төлбөр” гэж нэрлэдэг.

төлбөр” нь мөнгөөр үнэлэгдэх шинж чанаргүй учир түүнийг яг таг тогтоох боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг¹⁸.

Улмаар, 20-р зууны эхэн үед гарсан хэд хэдэн дээд шүүхийн жишгүүд 1) “тайтгарлын нөхөн төлбөр”-ийг төрөл бүрийн нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр шүүгч өөрийн үзэмжээр тогтооно 2) Шүүгч “тайтгарлын нөхөн төлбөр”-ийг тогтоосон үндэслэлээ ил болгох шаардлагагүй 3) Нэхэмжлэгч “сэтгэцэд учирсан хор уршиг”-аа нотлох шаардлагагүй хэмээх суурь зарчмуудыг тогтоож өгсөн¹⁹.

1950 он хүртэл, “Тайтгарлын нөхөн төлбөр”-ийг дээрх дээд шүүхийн жишгүүдийн хүрээнд шүүгч өөрийн үзэмжээр тогтоож байсан бөгөөд тодорхой хэрэг маргаанд яг ямар нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай вэ, түүнийг мөнгөөр хэрхэн үнэлэх вэ гэдэг дээр маш ярвигтай асуудлууд үүсэж байв. Судлаачдын зүгээс “тайтгарлын нөхөн төлбөр”-ийн хэмжээ хэт дур зоргын шинжтэй байгаа тул түүнийг өмнөх шүүхийн шийдвэрүүдэд тулгуурлан объектив, нэгдсэн стандартад оруулах шаардлагатай гэх саналуудыг дэвшүүлэх болсон байна. Ялангуяа, тухайн хувь хүний субъектив хохирлыг тайтгаруулах нөхөн төлбөр гэхээсээ илүүтэйгээр, нийгмийн зүгээс тухайн хохирлыг хэрхэн үнэлэх вэ гэдэгт анхаарлаа хандуулах шаардлагатай гэх шүүмжлэл хүчтэй байв²⁰.

Үүний үр дүнд, шүүхийн зүгээс өмнөх ижил төстэй шийдвэрүүдэд тулгуурлан нэгдсэн стандартыг бий болгох оролдлогуудыг хийж эхэлсэн байна. 1950 оноос авхуулан Япон Улсын эдийн засаг хурдацтай сэргэж, зам тээврийн осол тогтмол гарах болсон тул зам тээврийн ослоос үүдэх “тайтгарлын нөхөн төлбөр”-ийн жишиг стандартуудыг албан бус байдлаар анхан шатны шүүхүүд бэлтгэх болжээ. Гэтэл, анхан шатны шүүхүүд “тайтгарлын нөхөн төлбөр”-ийг тооцохдоо дээрх жишиг стандартуудыг нэг мөр баримталснаас үүдэн, практикт дээрх жишиг стандартууд маш чухал байр суурийг эзлэх болсон байна. Өнөө үед, зам тээврийн ослоос үүдэх “Тайтгарлын нөхөн төлбөр”-ийн жишиг стандартыг өмгөөлөгчдийн холбоо өмнөх шүүхийн жишгүүдэд тулгуурлан бэлтгэн гаргадаг. Энэхүү жишиг стандарт нь заавал дагаж мөрдөх шинжгүй ч бодит байдал дээр “тайтгарлын нөхөн төлбөр”-ийг тогтоох гол эх сурвалж болдог.

2. “Тайтгарлын нөхөн төлбөр”-ийг тогтоох жишиг стандарт

Шүүгч “Тайтгарлын нөхөн төлбөр”-ийн хэмжээг тухайн хэргийн төрөл бүрийн нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр өөрт тохиромжтой гэж үзсэн хэмжээгээр тогтоох нь “Тайтгарлын нөхөн төлбөр”-ийн гол зарчим юм²¹. Тайтгарлын нөхөн төлбөрийг тогтооход тухайн хэргийн бүхий л нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай хэдий ч, зарчмын хувьд дараах 10-н нөхцөл байдал голлох байр суурийг эзэлдэг²².

1) Хохирлын хэмжээ, төрөл, үргэлжилсэн хугацаа

¹⁸ 法務大臣官房司法法制調査部監修『法典調査会民法議事速記録五（日本近代立法資料叢書 5）』299 頁（商事法務研究会 1984 年）。

¹⁹ 大判明 34・12・20 刑録 7・11・105 頁、大判明 36・5・11 刑録 9・745、大判明 43・4・5 民録 16・273。

²⁰ 我妻榮『事務管理・不当利得・不法行為』135 頁（日本評論社 1937 [復刻：1988]）。

²¹ 藤村和夫「交通事故」斎藤修編『慰謝料算定の理論』33 頁参照（ぎょうせい 2010 年）。

²² 住田守道「人損慰謝料算定の諸問題と算定プロセス論」大阪府立大学経済研究 66 巻 3・4 号 17 頁、18 頁参照（2021 年）。

2) Онцгой нөхцөл байдал (Зулбах, үр хөндүүлэх, үргүй болох, сургууль завсардах, сонирхол бүхий спортоороо хичээллэх боломжгүй болох, ажлын байр солих, ажлаас гарах, тушаал дэвших боломжгүй болох г.м)

3) Хохирогчийн ажил мэргэжил, нийгмийн байр суурь, орлого, амьдралын түвшин,

4) Хууль бус үйлдлийн хэлбэр (Согтуу, Зөвшөөрөлгүй, Хэргийн газраас зугтсан зэрэг)

5) Гэм буруутай этгээдийн зан авир (Гэмшсэн байдал ажиглагдахгүй байх зэрэг)

6) Гэм буруутай этгээдийн байр суурь, боловсрол

7) Хохирогчийн ирээдүй

8) Хохирогч болон гэм буруутай этгээдийн хоорондын харилцаа

9) Хохирогчийн өөрийн гэм буруу

10) Тайтгарлын нөхөн төлбөрийн туслах чиг үүрэг (Эдийн хохирол хангалттай биш тохиолдолд түүнийг нөхөх г.м)

Бие махбодын гэмтлийн хувьд “Тайтгарлын нөхөн төлбөр”-ийг тогтооход хамгийн ач холбогдолтой нөхцөл байдал нь эхний нөхцөл байдал буюу хохирлын хэмжээ, төрөл болон үргэлжилсэн хугацаа юм. Бие махбодын гэмтэл нь зам тээврийн осолд хамгийн түгээмэл тохиолддог тул эхний нөхцөл байдал буюу хохирлын хэмжээ, төрөл, болон үргэлжилсэн хугацаанд тулгуурласан “Зам тээврийн ослоос үүдэх тайтгарлын нөхөн төлбөр” гэх жишиг стандартыг өмгөөлөгчдийн холбоо бэлтгэн гаргадаг²³.

Уг жишиг стандарт нь зарчмын хувьд зам тээврийн ослоос бий болох тайтгарлын нөхөн төлбөрийг тогтоох эх сурвалж болдог хэдий ч бие махбодын гэмтлээс үүдэх бүхий л төрлийн тайтгарлын нөхөн төлбөрт нэгэн адил хэрэглэгдэх болсон. Уг жишиг стандарт нь өмнөх шүүхийн шийдвэрүүдэд үндэслэн бичигддэг бөгөөд заавал дагаж мөрдөх шинжгүй. Гэсэн хэдий ч, ихэнх шүүхийн шийдвэрүүд юун түрүүнд жишиг стандартыг сууриа болгодог бөгөөд тухайн хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан “тайтгарлын нөхөн төлбөр”-ийг нэмэгдүүлэх эсхүл бууруулах үндэслэлүүдийг шийдвэртээ дурдаж өгдөг²⁴.

Жишиг стандартыг доорх хүснэгтээр харуулъя²⁵: Жишиг стандарт нь бие махбодод учирсан хохирлын төрлөөс шалтгаалан 1) нас барсан, 2) бие махбодын гэмтэл (эмчилгээ), 3) Хөгжлийн бэрхшээл хэмээх гурван төрөлтэй /1 иен= 26 төгрөг/.

Нас барсан (2009 оны байдлаар)

Гэр бүлийн тэжээн тэтгэгч	27 сая иен-31 сая иен
Ээж эсхүл Гэрлэгсэд	24 сая иен-27 сая иен
Бусад	20 сая иен-22 сая иен

²³ 藤村和夫・前掲注 (21) 34 頁参照。

²⁴ 藤村和夫・前掲注 (21) 38 頁参照。

²⁵ Жишиг стандарт нь угаас заавал дагаж мөрдөх шинжгүй тул, практикт төрөл бүрийн жишиг стандартууд хэрэглэгддэг. Хөнгөвчлөх үүднээс практикт голчлон баривдаг өмгөөлөгчдийн холбооны стандартыг харуулъя. Өмгөөлөгчдийн холбооны жишиг стандарт нь хамгийн өндөр үнийн дүнтэй。日弁連交通事故相談センター『交通事故損害賠償額算定基準—実務運用と解説』（平成 20 年）。

Бие махбодын гэмтэл авсан (2022 оны байдлаар)

Бие махбодын гэмтлийн тухайд хөнгөн гэмтэл болон хүнд гэмтэл гэсэн тус тусдаа стандарт бий.

Хөнгөн гэмтэл /Нэгж=Иен/

- Эмнэлэгт хэвтсэн хугацаа
- Эмчилгээнд хамрагдсан хугацаа

	0 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар
0 сар	0	350,000	660,000	920,000	1,160,000	1,350,000	1,520,000
1 сар	190,000	520,000	830,000	1,060,000	1,280,000	1,450,000	1,600,000
2 сар	360,000	690,000	970,000	1,180,000	1,380,000	1,530,000	1,660,000
3 сар	530,000	830,000	1,090,000	1,280,000	1,460,000	1,590,000	1,660,000
4 сар	670,000	950,000	1,190,000	1,360,000	1,520,000	1,650,000	1,720,000
5 сар	790,000	1,050,000	1,270,000	1,420,000	1,580,000	1,690,000	1,760,000
6 сар	890,000	1,130,000	1,330,000	1,480,000	1,620,000	1,730,000	1,800,000
7 сар	970,000	1,190,000	1,390,000	1,520,000	1,660,000	1,750,000	1,820,000
8 сар	1,030,000	1,250,000	1,430,000	1,560,000	1,680,000	1,760,000	1,830,000
9 сар	1,090,000	1,290,000	1,470,000	1,580,000	1,690,000	1,770,000	1,840,000
10 сар	1,130,000	1,330,000	1,490,000	1,590,000	1,700,000	1,780,000	1,860,000
11 сар	1,170,000	1,350,000	1,500,000	1,600,000	1,710,000	1,790,000	1,870,000
12 сар	1,190,000	1,360,000	1,510,000	1,610,000	1,720,000	1,800,000	1,880,000

Хүнд гэмтэл /Нэгж=Иен/

- Эмнэлэгт хэвтсэн хугацаа
- Эмчилгээнд хамрагдсан хугацаа

	0 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар
0 сар	0	530,000	1,010,000	1,450,000	1,840,000	2,170,000	2,440,000
1 сар	280,000	770,000	1,220,000	1,620,000	1,990,000	2,280,000	2,520,000
2 сар	520,000	980,000	1,390,000	1,770,000	2,100,000	2,360,000	2,600,000
3 сар	730,000	1,150,000	1,540,000	1,880,000	2,180,000	2,440,000	2,670,000
4 сар	900,000	1,300,000	1,650,000	1,960,000	2,260,000	2,510,000	2,730,000
5 сар	1,050,000	1,410,000	1,730,000	2,040,000	2,330,000	2,570,000	2,780,000
6 сар	1,160,000	1,490,000	1,810,000	2,110,000	2,390,000	2,620,000	2,820,000
7 сар	1,240,000	1,570,000	1,880,000	2,170,000	2,440,000	2,660,000	2,860,000
8 сар	1,320,000	1,640,000	1,940,000	2,220,000	2,480,000	2,700,000	2,900,000
9 сар	1,390,000	1,700,000	1,990,000	2,260,000	2,520,000	2,740,000	2,920,000
10 сар	1,450,000	1,750,000	2,030,000	2,300,000	2,560,000	2,760,000	2,940,000
11 сар	1,500,000	1,790,000	2,070,000	2,340,000	2,580,000	2,780,000	2,960,000
12 сар	1,540,000	1,830,000	2,110,000	2,360,000	2,600,000	2,800,000	2,980,000

Хөгжлийн бэрхшээл (2009 оны байдлаар)- Хөгжлийн бэрхшээлийн түвшний зэрэглэлийг Япон Улсын эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас баталдаг.

1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин
27 сая иен-31 сая иен	23 сая иен-27 сая иен	18 сая иен-22 сая иен	15 сая иен-18 сая иен
5-р түвшин	6-р түвшин	7-р түвшин	8-р түвшин
13 сая иен-15 сая иен	11 сая иен-13 сая иен	9 сая иен-11 сая иен	7.5 сая иен-8.7 сая иен
9-р түвшин	10-р түвшин	11-р түвшин	12-р түвшин
6 сая иен-7 сая иен	4.8 сая иен-5.7 сая иен	3.6 сая иен-4.3 сая иен	2.5 сая иен-3 сая иен
13-р түвшин	14-р түвшин		
1.6 сая иен-1.9 сая иен	900,000-1.2 сая иен		

Түвшний зэрэглэлийн тодорхойлолт

	Түвшний зэрэглэлийн тодорхойлолт
1-р түвшин	-Бүтэн хараагүй болсон -Хоол боловсруулах мөн хэл ярианы бүрэн чадваргүй болсон -Тохойноос дээш гарын 2 мөч алдсан -Хоёр гарын хэрэглээг бүрэн алдсан -Өвдөгний үеэс дээш хөлийн 2 мөч алдсан -Хоёр хөлийн хэрэглээг бүрэн алдсан
2-р түвшин	-Нэг нүдний харааг бүрэн алдсан ба нөгөө нүдний хараа 0.02-оос багассан -Хоёр нүдний хараа 0.02-оос багассан -Бугуйн үенээс дээш 2 гарын мөчийг алдсан -Шагайн үенээс дээш 2 хөлийн мөчийг алдсан

3-р түвшин	<ul style="list-style-type: none"> -Нэг нүдний харааг бүрэн алдсан ба нөгөө нүдний хараа 0.06-аас багассан -Хоол боловсруулах эсхүл хэл ярианы чадваргүй болсон -Мэдрэлийн системд ихээхэн хэмжээний хохирол учирч, насан туршдаа хөдөлмөрийн чадвараа алдсан -Хэвлийн эрхтнүүдийн үйл ажиллагаа ихээхэн доголдож, насан туршдаа хөдөлмөрийн чадвараа алдсан -Хоёр гарын бүх хурууг алдсан
4-р түвшин	<ul style="list-style-type: none"> -Хоёр нүдний хараа 0.06-аас багассан -Хоол боловсруулах мөн хэл ярианы чадварт ихээхэн бэрхшээл учирсан -Хоёр чихний сонсох чадвар бүрэн алдсан -Нэг гарын тохойн үенээс дээш мөчийг алдсан -Нэг хөлийн өвдөгний үеэс дээш мөчийг алдсан -Хоёр гарын бүх хурууны хэрэглээгээ алдсан -Лисфранкийн үенээс дээш 2 хөлөө алдсан
5-р түвшин	<ul style="list-style-type: none"> -Нэг нүдний харааг алдсан ба нөгөө нүдний хараа 0.1-ээс багассан -Мэдрэлийн тогтолцооны үйл ажиллагаа, оюун санааны үйл ажиллагаа ихээхэн согогтой болсон ба хөнгөн хөдөлмөрөөс өөр ажил эрхлэх чадваргүй болсон -Хэвлийн эрхтнүүдийн үйл ажиллагаанд ихээхэн хэмжээний доголдол бий болсон ба хөнгөн хөдөлмөрөөс өөр ажил эрхлэх чадваргүй болсон -Нэг гарын бугуйн үенээс дээш мөчийг алдсан -Нэг хөлийн шагайны үеэс дээш мөчийг алдсан -Нэг гарын хэрэглээг бүрэн алдсан -Нэг хөлийн хэрэглээг бүрэн алдсан -Хоёр хөлийн бүх хуруугаа алдсан
6-р түвшин	<ul style="list-style-type: none"> -Хоёр нүдний хараа 0.1-ээс багассан -Хоол боловсруулах болон хэл ярианы чадварт ихээхэн доголдол үүссэн -Хоёр чихний сонсгол нь чихэндээ хүргэхгүй л бол чанга дууг ойлгохгүй байх хэмжээнд хүрсэн -Нэг чихний сонсголыг бүрэн алдсан, нөгөө чихний сонсгол 46 см-ээс хол зайны дуу чимээг ойлгох чадваргүй болсон -Нурууны баганад гажилт үүссэн эсхүл хөдөлгөөний эмгэгтэй болсон -Нэг гарын 3н гол үений 2-ийг хэрэглэхээ больсон -Нэг хөлийн 3н гол үений 2-ийг хэрэглэхээ больсон -Нэг гарын бүх хуруу эсхүл эрхий хурууг оруулаад 4н хуруу алдсан
7-р түвшин	<ul style="list-style-type: none"> -Нэг нүд нь хараагүй болсон ба нөгөө нүдний хараа 0.6-аас багассан -Хоёр чихний сонсгол 46 см-ээс хол зайны дуу чимээг ойлгох чадваргүй болсон -Нэг чихний сонсголыг бүрэн алдсан ба нөгөө чихний сонсгол 1 метр-ээс хол зайны дуу чимээг ойлгох чадваргүй болсон -Мэдрэлийн тогтолцоо болон сэтгэцийн хувьд доголдолтой болсон ба хөнгөн хөдөлмөрөөс бусад төрлийн ажил эрхлэх чадваргүй болсон -Хэвлийн эрхтнүүдийн үйл ажиллагаа алдагдсанаас хөнгөн хөдөлмөрөөс бусад хөдөлмөр эрхлэх чадваргүй болсон -Нэг гарын эрхий хурууг оруулаад гурван хуруугаа алдсан, эсхүл эрхий хуруунаас бусад 4н хуруугаа алдсан -Нэг гарын бүх хурууны хэрэглээг алдсан эсхүл эрхий хурууг оруулаад 4н хурууны хэрэглээг алдсан -Нэг хөлийн лисфранкаас дээш мөчийг алдсан -Гарын хугарал эдгэрэх боломжгүй болсон ба хөдөлгөөнд их хэмжээний доголдол үүссэн -Хөлийн хугарал эдгэрэх боломжгүй болсон ба хөдөлгөөнд их хэмжээний доголдол үүссэн -Хоёр хөлийн хурууг хэрэглэх чадваргүй болсон -Гадаад төрхөд их хэмжээний гажиг үлдсэн -Хоёр төмсөггүй болсон

8-р түвшин	<ul style="list-style-type: none"> -Нэг нүдний харааг алдсан, эсхүл нэг нүдний хараа 0.02-оос багассан -Нуруунд хөдөлгөөний эмгэгтэй болсон -Нэг гарын эрхий хурууг оруулаад 2 хурууг алдсан эсхүл 3н хурууг алдсан -Нэг гарын эрхий хурууг оруулаад 3н хурууны хэрэглээг алдсан эсхүл 4н хурууны хэрэглээг алдсан -Доод мөч 5 см-аас илүү багассан -Нэг гарын 3н гол үеийн 1-ийн хэрэглээг алдсан -Нэг хөлийн 3н гол үеийн 1-ийн хэрэглээг алдсан -Нэг гарын хугарал эдгэрэх боломжгүй болсон -Нэг хөлийн хугарал эдгэрэх боломжгүй болсон -Нэг хөлийн бүх хурууг алдсан
9-р түвшин	<ul style="list-style-type: none"> -Хоёр нүдний хараа 0.6-аас багассан -Нэг нүдний хараа 0.06-ас багассан -Хоёр нүд хагас хараагүй болсон, харааны талбай нарийссан, харааны талбайн өөрчлөлт орсон -Хоёр нүдний зовхинд мэдэгдэхүйц согогтой болсон -Хамар гэмтсэн ба үйл ажиллагаанд их хэмжээний доголдол үүссэн -Хоол боловсруулах болон хэл ярианы үйл ажиллагаа доголдсон -Хоёр чихний сонсгол 1 метрээс хол зайны дуу чимээг ойлгох чадваргүй болсон -Нэг чихний сонсгол чихэндээ ойртуулахгүй л бол ойлгох чадваргүй болсон ба нөгөө чихний сонсгол 1 метрээс хол зайны дуу чимээг ойлгоход бэрхшээлтэй болсон -Нэг чихний сонсголыг бүрэн алдсан -Мэдрэлийн тогтолцоо эсхүл оюун санааны үйл ажиллагаанд доголдол үүссэн ба эрхлэх боломжтой хөдөлмөр хязгаарлагдсан -Цээжний болон хэвлийн эрхтнүүдийн үйл ажиллагаа доголдсон, эрхлэх боломжтой хөдөлмөр хязгаарлагдсан -Нэг гарын эрхий хуруу эсхүл 2 хурууг алдсан -Нэг гарын эрхий хурууг оруулаад 2 хурууны хэрэглээг алдсан эсхүл 3н хурууны хэрэглээг алдсан -Нэг хөлийн эрхий хурууг оруулаад 2 хуруу алдсан -Нэг хөлийн бүх хурууны хэрэглээг алдсан -Гадаад төрхөд мэдэгдэхүйц гажиг үлдсэн -Нөхөн үржихүйн эрхтэнд их хэмжээний доголдол үүссэн
10-р түвшин	<ul style="list-style-type: none"> -Нэг нүдний хараа 0.6-аас багассан -Давхар харааны эмгэгтэй болсон -Хоол боловсруулах эсхүл хэл ярианы үйл ажиллагаанд доголдол бий болгох -14-ээс дээш шүдэнд хиймэл шүд хийлгэсэн -Хоёр чихний сонсгол 1 метрээс холын зайны энгийн дуу чимээг ойлгоход хүндрэлтэй болсон -Нэг чихний сонсгол чихэндээ ойртуулахгүй л бол ойлгох чадваргүй болсон -Нэг гарын эрхий хуруу эсхүл 2 хуруу алдсан -Доод мөч 3 см-ээс их хэмжээгээр багассан -Нэг хөлийн эрхий хуруу эсхүл бусад 4н хуруу алдсан -Нэг дээд мөчний 3н гол үеийн 1-ийн ажиллагаа их хэмжээгээр доголдсон -Нэг доод мөчний 3н гол үеийн 1-ийн ажиллагаа их хэмжээгээр доголдсон
11-р түвшин	<ul style="list-style-type: none"> -Хоёр нүдний алимын хөдөлгөөн доголдсон -Хоёр нүдний зовхины хөдөлгөөн их хэмжээгээр доголдсон -Нэг нүдний зовхи их хэмжээгээр гэмтсэн -10-ээс дээш тооны шүдэнд хиймэл шүд хийсэн -Хоёр чихний сонсгол 1 метрээс хол зайны намуухан дууг ойлгох чадваргүй болсон -Нуруу гажигтай болсон -Нэг гарын долоовор хуруу ба дунд хуруу эсхүл ядам хурууг алдсан

	<p>-Нэг хөлийн эрхий хурууг оруулаад 2 хөлийн хурууны хэрэглээг алдсан</p> <p>-Цээж хэвлийн эрхтнүүдийн үйл ажиллагаа, доголдож ажил хөдөлмөр эрхлэхэд бэрхшээл үүссэн</p>
12-р түвшин	<p>-Нэг нүдний алимын хөдөлгөөн доголдсон</p> <p>-Нэг нүдний зовхины хөдөлгөөн их хэмжээгээр доголдсон</p> <p>-7-оос дээш тооны шүдэнд хиймэл шүд хийсэн</p> <p>-Нэг чихний ихэнх хэсгийг алдсан</p> <p>-Эгэм, өвчүүний яс, хавирга, шөрмөс эсхүл аарцгийн ясанд мэдэгдэхүйц гажилт үүссэн</p> <p>-Дээд мөчний 3н гол үений нэгний үйл ажиллагаанд доголдол үүссэн</p> <p>-Доод мөчний 3н гол үений нэгний үйл ажиллагаанд доголдол үүссэн</p> <p>-Урт ясанд гажиг үлдсэн</p> <p>-Нэг гарын чигчий хурууг алдсан</p> <p>-Нэг гарын долоовор хуруу, дунд хуруу эсхүл ядам хурууг ашиглах боломжгүй болсон</p> <p>-Нэг хөлийн долоовор хурууг алдсан ба долоовор хурууг оруулаад хоёр хуруу алдсан эсхүл дунд хурууг оруулаад 3н хуруу алдсан</p> <p>-Нэг хөлийн эрхий хуруу эсхүл 4н хурууны хэрэглээг алдсан</p> <p>-Байнгын сэтгэцийн эмгэгтэй болсон</p> <p>-Гадаад төрхөд гажиг үлдсэн</p>
13-р түвшин	<p>-Нэг нүдний хараа 0.6-аас багассан</p> <p>-Давхар харааны эмгэгтэй болсон</p> <p>-Нэг нүд хагас хараагүй болсон, харааны талбай нарийссан, харааны талбайн өөрчлөлт орсон</p> <p>-Хоёр нүдний зовхи гэмтсэн эсхүл</p> <p>-5-аас дээш шүдэнд хиймэл шүд хийсэн</p> <p>-Нэг гарын чигчийн хурууг алдсан</p> <p>-Нэг гарын эрхий хурууны нэг хэсгийг алдсан</p> <p>-Доод мөч 1 см-ээс их хэмжээгээр богиноссон</p> <p>-Нэг хөлийн дунд хуруунаас доош 1 эсхүл 2 хурууг алдсан</p> <p>-Нэг хөлийн 2 хурууг ашиглах боломжгүй болсон, долоовор хурууг оруулаад 2 хурууг ашиглах боломжгүй болсон, эсхүл дунд хуруунаас хойших 3н хурууг ашиглах боломжгүй болсон</p> <p>-Цээж хэвлийн эрхтнүүдийн үйл ажиллагаа доголдсон</p>
14-р түвшин	<p>-Нэг нүдний зовхи гэмтсэн</p> <p>-3-аас дээш тооны шүдэнд хиймэл шүд хийсэн</p> <p>-Нэг чихний сонсгол 1 метрээс хол зайны намуухан дуу чимээг ойлгох чадваргүй болсон</p> <p>-Дээд мөчний гадна талд том сорви үлдээсэн</p> <p>-Доод мөчний гадна талд том сорви үлдээсэн</p> <p>-Нэг гарын эрхий хуруунаас бусад хурууны нэг хэсгийг алдсан</p> <p>-Нэг гарын эрхий хуруунаас бусад хурууны алслагдсан завсрын үеийг нугалж, сунгах чадваргүй болсон</p> <p>-Нэг хөлийн дунд хуруунаас дооших 1 эсхүл 2 хурууг ашиглах боломжгүй болсон</p> <p>-Сэтгэцийн эмгэгтэй болсон</p>

3. “Тайтгарлын нөхөн төлбөр”-ийг тооцох аргачлал

Япон Улсад, “Тайтгарлын нөхөн төлбөр”-ийг эдийн бус хохиролтой холбогдох бүхий л төрлийн хэрэг маргаанд нөхөн төлдөг. “Тайтгарлын нөхөн төлбөр” хөндөгдөх дараах гол маргааны төрлүүдийг дурдаж болно.

- Зам тээврийн осол (Бие махбодын гэмтэл)
- Эмч эмнэлгийн байгууллагын буруутай үйл ажиллагаа (Medical malpractice)
- Нэр хүнд болон нууцын эрхийн зөрчил (defamation and privacy)

- Хөдөлмөрийн харилцаа (Осол, Ялгаварлан гадуурхалт, г.м)
- Сургуулийн орчмын осол (Осол, ялгаварлан гадуурхалт г.м)
- Гэрлэлт, Араар тавилт
- Хүрээлэн буй орчин, эмийн бүтээгдэхүүний доголдол
- Барилга байгууламж, техник хэрэгслийн осол
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, санхүүгийн зах зээл
- Харассмент дарамт

Дээрх маргааны төрөл бүр бусад маргааны төрлөөс ялгагдах онцлог болон тулгамддаг асуудалтай байдаг тул бүх маргааны төрөлд тохирох “тайтгарлын нөхөн төлбөр”-ийг тооцох аргачлал гэж байдаггүй. Түгээмэл тохиолддог маргаанд “зам тээврийн ослоос үүдэх тайтгарлын нөхөн төлбөр” зэрэг жишиг стандарт нь голлох эх сурвалж болдог хэдий ч, бусад маргааны төрлүүдэд жишиг стандарт нь ач холбогдолгүй. Түүнчлэн “тайтгарлын нөхөн төлбөр”-ийн хэмжээ нь тухайн хэргийн нөхцөл байдлаас шалтгаалдаг учир, анхан шатны шүүх өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд “тайтгарлын нөхөн төлбөр”-ийг тогтоодог бөгөөд дээд шүүхийн жишиг ч мөн ач холбогдолгүй байдаг. Эцсийн дүндээ тухайн маргааны төрөлтэй төсөөтэй хэрэгт өмнөх шүүхийн шийдвэрүүд “тайтгарлын нөхөн төлбөр”-ийг хэрхэн тогтоосон бэ гэдэг голлох эх сурвалж болдог.

“Зам тээврийн ослоос үүдэх тайтгарлын нөхөн төлбөрийн жишиг стандарт” байгаа тохиолдолд, юун түрүүнд тухайн жишиг стандартаас тогтоож өгсөн үнийн дүн “тайтгарлын нөхөн төлбөр”-ийн үндэс болдог. Харин тухайн хэрэгт жишиг стандартын үнийн дүнг нэмэгдүүлэх эсхүл бууруулах онцгой нөхцөл байдал байгаа гэж үзэх тохиолдолд, шүүгч тухайн онцгой нөхцөл байдлыг шийдвэртээ дурдаж өгсний үндсэн дээр “тайтгарлын нөхөн төлбөр”-ийг жишиг стандартаас нэмэгдүүлэн эсхүл бууруулан тогтоодог²⁶.

1) Гэм буруугийн агуулга, хэлбэр, хорон санаанаас үүдэж тайтгарлын нөхөн төлбөр жишиг стандартаас өндөр тогтоогдсон тохиолдол

Осака хотын анхан шатны шүүх 2006.11.30 (自保ジャーナル 1713・20)-ийн хэрэгт, ногоон гэрлээр зам гарч явсан бага сургуулийн 1 дүгээр ангийн охиныг Том тээврийн ачааны автомашин хурдаа хасалгүйгээр мөргөж амь насыг хохироосон хэрэгт тайтгарлын нөхөн төлбөр хохирогчид 30 сая иен, аавд 3 сая иен, ээж гэмтлийн дараах стрессийн эмгэгээр (PTSD) оношлогдсон тул 4 сая иен нийт 32 сая иений тайтгарлын нөхөн төлбөрийг тогтоосон.

Осака хотны анхан шатны шүүх 2006.02.16 (交通民集 39・1・205)-ийн хэрэгт, 17 настай хүүхдийг дайрч амь насыг нь хохироосон бөгөөд шүүхийн зүгээс гэм буруутай этгээд жолооны зөвшөөрөлгүй байсан, согтуудаа жолоо барьсан, осол болсны дараа хохирогчийн хувцаснаас татаж, буцаан шидсэн зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр 39 сая иений тайтгарлын нөхөн төлбөрийг тогтоосон.

Осака хотны анхан шатны шүүх 2007.12.14 (平成 19 年 (ウ) 5490 号)-ийн хэрэгт, 11 настай охин машинд мөргүүлэн 8-р түвшний хөгжлийн бэрхшээлтэй болсон бөгөөд гэм буруутай этгээд хохирогчийн сэтгэл санааг шархлуулах үг хэллэг хэлсэн гэдэг үндэслэлээр тайтгарлын нөхөн төлбөрийг 30%-иар нэмэгдүүлж, ирээдүйд сургууль завсардах явдлыг мөн харгалзан дахин 20%-иар нэмэгдүүлсэн.

2) Осол болсны дараах гэм буруутай этгээдийн хандлагаас үүдэж тайтгарлын нөхөн төлбөр нэмэгдсэн тохиолдол

²⁶ 藤村和夫・前掲注 (21) 38-45 頁参照。

Ёокохама хотын анхан шатны шүүх 2008.10.01 (平成 19 年 (ウ) 5113 号) -ийн хэрэгт, машин мөргөлдсөний улмаас 79 настай эрэгтэй нас барсан бөгөөд гэм буруутай этгээд нь удаан хугацааны турш уучлал гуйгаагүй, зөвхөн өөрийн хариуцлагыг бууруулахад л анхаарлаа хандуулсан, худал мэдүүлэг өгсөн, үр хойчийнх нь сэтгэл санааны хохирлыг нэмэгдүүлсэн зэрэг үндэслэлээр тайтгарын нөхөн төлбөрийг нэмэгдүүлсэн.

Нагоя хотын анхан шатны шүүх 2008.10.10 (交通民集 41・5・1332) -ийн хэрэгт, машин мөргөлдсөний улмаас 37 настай эрэгтэй нас барсан бөгөөд хохирогч нь осол болохоос өмнөхөн гэрлэлтээ батлуулсан, ослын дараа гэм буруутай этгээд “Би уучлал гуйхаар зүйл хийсэн байж болох ч, гэмшихээр зүйл ерөөсөө хийгээгүй” гэж хэлсэн, гэм буруутай этгээд хохирогчийн эхнэрээс уучлалт гуйгаагүй, хохирогчийг оршуулах ёслолд оролцоогүй зэрэг үндэслэлээр тайтгарлын нөхөн төлбөрийн хэмжээг 32 сая иенээр тогтоосон.

3) Хохирогчийн онцгой нөхцөл байдал, хандлага

Осака хотын анхан шатны шүүх 2009.01.30 (交通民集 42・1・101)-ийн хэрэгт, 1 настай охин нүүрэндээ хөгжлийн бэрхшээлийн 12-р түвшний сорвитой болсон бөгөөд шүүхийн зүгээс эмэгтэй хүүхдийн хувьд нүүрний сорви түүний амьдралд үзүүлэх нөлөөг харгалзан үзэж жишиг стандартын тайтгарлын нөхөн төлбөрийг 2 дахин нэмэгдүүлэн тогтоосон.

Ёокохама хотын анхан шатны шүүх 2008.04.25 (自保ジャーナル 1744・20)-ийн хэрэгт, хохирогч нь бүх бурууг гэм буруутай этгээдэд үүрүүлэхийг оролдсон гэдэг үндэслэлээр жишиг стандартын нөхөн төлбөрийг 10%-иар бууруулан тогтоосон.

2.2. Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-д сэтгэцэд учирсан хор уршигтай холбоотой нэр томъёог хэрхэн ойлгодог, нөхөн төлбөрийн хэмжээг тооцохдоо хохирогчийн насны ялгаатай байдлыг харгалзаж үздэг эсэх, мөн нөхөн төлбөрийг тооцох стандарт буюу нөхөн олгож болох дээд ба доод хэмжээг тогтоосон эсэх талаар энэ бүлэгт авч үзнэ.

1. Нэр томъёоны тайлбар

“정신적 손해배상” буюу “сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөр” гэсэн нэр томъёог Солонгосын эрх зүйн ном сэтгүүл болон шүүхийн практикт өргөн хэрэглэдэг. Үгчлэн орчуулбал, 정신적 гэдэг нь mental буюу сэтгэцийн, оюун санааны, 손해 гэдэг нь damage/harm буюу хохирол/хор уршиг, 배상 гэдэг нь compensation буюу нөхөн төлбөр гэж ойлгож болно.

Солонгос хэлний их толь бичигт “정신”²⁷ гэдэг үгийг “хүний тархины үйл ажиллагаанаас үүдэлтэй өндөр түвшний санаа, бодлын үйл ажиллагаа эсвэл түүний хүрээ”, “аливаа зүйлийг мэдрэх, бодох чадвар ба тэрхүү үйлдэл”, “손해”²⁸ гэдэг үгийг “алдсан ашиг”, “хохирол”, “손해배상”²⁹ гэдэг үгийг “хуульд заасан журмын дагуу бусдад учруулсан хохирлыг барагдуулах” гэж тус тус тайлбарласан байна.

²⁷ Солонгос хэлний их толь бичиг. 1999 он. 2937 дахь тал.

²⁸ Солонгос хэлний их толь бичиг. 1996 он. 1893 дахь тал.

²⁹ Мөн тэнд. Эшлэл 2.

Хуулийн тайлбар толь бичигт “손해배상” гэдэг үгийг англиар “compensation for damage”, монголоор “хохирол учруулсны нөхөн төлбөр”³⁰, мөн “compensation/indemnification for damage”³¹ гэж тус тус орчуулсан байна.

Үүнээс харвал толь бичгүүдэд сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийг нэг янзаар тэмдэглэж, ойлгодог буюу сэтгэц, сэтгэл санаа болон хохирол, хор уршгийг салгаж авч үздэггүй нь харагдаж байна.

2. Насны ялгаатай байдал

БНСУ-ын Иргэний хуулийн 751 дүгээр зүйлд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх төлбөрийн тухай тусгагдсан байна.

751 дүгээр зүйл³²

- 1. Бусдын бие махбод, эрх чөлөө, нэр хүндийг хохироосон, эсвэл сэтгэцийн хямрал учруулсан этгээд түүнээс учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.*
- 2. Шүүх өмнөх хэсэгт заасан хохирлын нөхөн төлбөрийг давтамжтай төлүүлэхээр үүрэг болгож, түүний гүйцэтгэлийг хангахын тулд ихээхэн хэмжээний баталгаа гаргахыг даалгаж болно.*

Хэдийгээр 751 дүгээр зүйлд гэм хороос үүдэлтэй эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тухай заасан ч ямар аргачлалаар, ямар хүчин зүйлсийг харгалзан үзэж нөхөн төлбөрийг тооцохыг тайлбарлаагүй байна. Ингээд энэ нь эцэстээ шүүгч нарын шийдэх ёстой асуудал болдог.³³

Нөхөн төлбөрийг тооцох стандарт байхгүй учраас хохирлыг арилгах ажиллагааг аль болох шударга байлгахын тулд шүүх хохирлын мөн чанарыг олж тогтоохын зэрэгцээ шаардлагатай бүх нөхцөл байдлыг тооцож үзэхийг хичээдэг байна.³⁴ Шүүх нь сэтгэцэд учирсан хор уршгийн хэмжээг тооцохдоо хохирогчийн зовлон шаналал, эд хөрөнгийн байдал, амьдралын нөхцөл байдал, эрхэлсэн ажил, албан тушаал, нас, харьяалал, хохирогчийн хайхрамжгүй байдал, эд хөрөнгийн хохирлын хэмжээ зэрэг янз бүрийн нөхцөл байдлыг харгалзан үздэг. Энэхүү нөхөн төлбөрийг хохирогчийн сэтгэл санааны өвдөлтийг багасгах зорилгоор олгодог тул БНСУ нь ихэнх улс орнуудын нэгэн адил хохирогчийн өвдөлтийн зэргийг хамгийн чухал үзүүлэлт гэж үздэг.³⁵

Харгалзаж үзэх хүчин зүйлс:³⁶

1. Хохирогчийн нөхцөл байдал
 - а) Хохирогчийн амссан зовлон

³⁰ Солонгосын хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн, МУ-ын Хууль зүйн үндэсний хүрээлэн. Англи Солонгос Монгол Хууль зүйн толь. 2010 он. 93 дахь тал.

<https://www.klri.re.kr/kor/publication/922/view.do>, (Сүүлд үзсэн: 2023.03.27).

³¹ БНСУ-ын Засгийн газрын Хууль зүйн яам. Солонгос, англи хэл дээрх хуулийн тайлбар толь. 2008 он. 221 дэх тал. <https://www.klri.re.kr/kor/publication/922/view.do>, (Сүүлд үзсэн: 2023.03.27).

³² БНСУ-ын Иргэний хууль. 2022 он.

<https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EB%AF%BC%EB%B2%95/%EC%A0%9C751%EC%A1%B0> Сүүлд үзсэн: 2023.03.27

³³ Жү Хён Жүн. Хууль бус үйлдлийн улмаас сэтгэцэд учирсан хохирлын нөхөн төлбөрийн хариуцлагын тухай судалгаа /магистрын ажил/. 2019 он. 57 дахь тал.

https://dcollection.pusan.ac.kr/public_resource/pdf/000000141402_20230327095032.pdf, (Сүүлд үзсэн: 2023.03.27).

³⁴ Мөн тэнд. Эшлэл 7. 57-58 дахь тал.

³⁵ Чой Хён Шик. Хууль бус үйлдлийн улмаас сэтгэцэд учирсан хохирлын нөхөн төлбөрийн тухай судалгаа /докторын ажил/. 2016 он. 43 дахь тал.

http://gachon.dcollection.net/public_resource/pdf/000002237005_20230327103351.pdf, (Сүүлд үзсэн: 2023.03.27).

³⁶ Жү Хён Жүн. Хууль бус үйлдлийн улмаас сэтгэцэд учирсан хохирлын нөхөн төлбөрийн хариуцлагын тухай судалгаа /магистрын ажил/. 2019 он. 58 дахь тал.

- b) Хохирогчийн хайхрамжгүй байдал
 - c) Хохирогчийн нас, ажил мэргэжил, боловсрол, нийгмийн байр суурь
 - d) Хохирогчийн эд хөрөнгийн байдал
 - e) Хохирогчийн амьдралын нөхцөл байдал
 - f) Олон хохирогч байгаа тохиолдол
2. Хохирол учруулагчийн нөхцөл байдал
- a) Хохирол учруулагчийн санаатай эсвэл хайхрамжгүй байдал
 - b) Хохирол учруулагчийн эд хөрөнгийн байдал
 - c) Хохирол учруулагчийн нийгмийн байр суурь, ажил мэргэжил, боловсрол, нас
 - d) Хохирол учруулагчийн ослын дараах хандлага
 - e) Хохирол учруулагчид эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн эсэх

Дээр дурдсан нөхөн төлбөрийг тооцохдоо харгалзаж үзэх хүчин зүйлсийн нэг болох хохирогчийн нас, ажил мэргэжил, боловсрол, нийгмийн байр суурийн тухай дэлгэрэнгүй авч үзье. Учирсан хохирол адилхан боловч хохирогчийн нас, эрхэлсэн ажил, боловсрол, нийгмийн байр сууриас хамаараад түүний мэдрэх зовлон шаналлын түвшин өөр байхаас аргагүй.

Практикт хүний биед гэмтэл учруулсан тохиолдолд сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийн хэмжээг залуу хүн, хөгшин хүн гэж ялгаж тооцдог байна. Учир нь залуу хүний биед учирсан гэмтэл нь түр зуурын бус насан туршийн шарх хэвээр үлдвэл түүний цаашид амьдрах явцад мэдрэх ёстой сэтгэлийн зовлон шаналал нь амьдрах богино хугацаа үлдсэн хөгшин хүнийхтэй адилхан хэмжигдэх боломжгүй юм.³⁷ Хэдийгээр наснаас хамаараад ялгаатай авч үздэг гэж байгаа боловч тодорхой үечилсэн тогтсон стандарт, схем байхгүй байгааг дурдах нь зүйтэй.

Мөн гүтгэлэг гэх мэт бусдад нөлөөлөх түвшин нь нийгмийн байр сууриас хамаарч өөр өөр байх тохиолдолд нийгмийн байр суурь, эрхэлсэн ажил, боловсрол зэрэг нь нөхөн төлбөрийн хэмжээг тооцохдоо харгалзан үзвэл зохих хүчин зүйлүүд юм.³⁸

3. Сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийг тооцох стандарт

2015 оны 3 дугаар сарын 1-ний өдөр Сөүл хотын төв дүүргийн шүүх нь сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийг тооцох стандартыг хянан хэлэлцсэн байна. Үнийн түвшин, эдийн засгийн цар хүрээ, гишүүдийн нийтлэг эрх зүйн дүгнэлт зэрэг янз бүрийн нөхцөл байдлыг харгалзан үзээд сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийг тооцох өнөөгийн жишиг доогуур байна гэж үзэн нөхөн төлбөрийн хэмжээг 80 сая вон байсныг 100 сая вон болгон нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн байна. 1991 оноос өмнө 20 сая вон, 1991 онд 30 сая вон, 1996 онд 40 сая вон, 1999 онд 50 сая вон, 2007 онд 60 сая вон, 2008 онд 80 сая вон, 2015 онд 100 сая вон тус тус хүрчээ. Гэвч энэ нь зөвхөн Сөүл хотын төв дүүргийн шүүхээр хүлээн зөвшөөрөгдсөн стандарт бөгөөд улс орон даяар бүх шүүхүүдэд нь хэрэгждэг стандарт биш юм.³⁹ Ийнхүү 2015 онд 100 сая вон болгож нэмэгдүүлснээс хойш 2017 онд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон эсвэл хүн дайрч зугтсанаас болж хохирогч нас барсан тохиолдолд сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрт 200 сая вон хүртэл олгохыг хүлээн зөвшөөрсөн байна.⁴⁰

³⁷ Жү Хён Жүн. Хууль бус үйлдлийн улмаас сэтгэцэд учирсан хохирлын нөхөн төлбөрийн хариуцлагын тухай судалгаа /магистрын ажил/. 2019 он. 59 дэх тал. https://dcollection.pusan.ac.kr/public_resource/pdf/000000141402_20230327095032.pdf, (Сүүлд үзсэн: 2023.03.27).

³⁸ Ким Сан Юн. Гэм хорын эрх зүй. 1997 он. 492 дахь тал.

³⁹ Жү Хён Жүн. Хууль бус үйлдлийн улмаас сэтгэцэд учирсан хохирлын нөхөн төлбөрийн хариуцлагын тухай судалгаа /магистрын ажил/. 2019 он. 64 дэх тал. https://dcollection.pusan.ac.kr/public_resource/pdf/000000141402_20230327095032.pdf, (Сүүлд үзсэн: 2023.03.27).

⁴⁰ Мөн тэнд. Эшлэл 13. 42 дахь тал.

Сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийн хэмжээг тооцохдоо хохирогчийн хайхрамжгүй байдлыг Дээд шүүх харгалзаж үздэг байна. Жишээ нь, зам тээврийн ослын үед хэрэв хохирогч буруутай бол Анхан шатны шүүх нөхөн төлбөрийн хэмжээг тооцохдоо хохирогчийн хайхрамжгүй байдлыг 6/10-аар үржүүлж боддог.⁴¹

Хууль бус үйлдлийн улмаас сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийн хэмжээ (БНСУ-ын шүүхийн хууль эрх зүйн цогц мэдээллийн сан. 2012.1.1-2015.9.25)⁴²

(нэгж:10000 вон)

Ангилал		Хэргийн тоо	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ	Доод хэмжээ	Онцлог
Нөхөн төлбөрийн нийт дүн		58	1380	5600	50	
Амьд явах эрхэд халдсан		14	2000-3000	5600	500	
Бие махбод болон эрүүл мэндэд халдсан		12	1000-1500	5000	250	Бэлгийн хүчирхийллээс үүдэлтэй сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ хамгийн өндөр ба биеийн гэмтлийн зэргээс хамааран нөхөн олговрын хэмжээ харилцан адилгүй байна.
Эрх чөлөөнд халдсан	Бүгд	17	700-1000	4000	50	Алдагдсан боломжийн нөхөн төлбөрийн хэмжээ хамгийн өндөр.
	Хувийн нууц	3		100	50	
	Эмчийн дүгнэлт	6	1000	4000	200	Өвчтөний хүсэл зоригоос үл хамааран биед нь өөрчлөлт орсон тохиолдолд нөхөн төлбөрийн хэмжээ өндөр.
	Алдагдсан боломж	4	1100	2000	700	Эмнэлэг буруутай үйл ажиллагаа явуулсан ба түүнийгээ тайлбарлаагүй тохиолдолд нөхөн төлбөрийн хэмжээ өндөр.
	Бусдын эрх чөлөө	4	250	500	100	Хувийн орон зайнд халдсан тохиолдолд нөхөн төлбөрийн хэмжээ өндөр.
Гүтгэлэг		4	1500-2000	2000	500	
Гэр бүл салалтын тэтгэлэг		5	2000	3000	2000	
Дүрсийн эрхийн зөрчил		2		1500	300	Дүрсийн эрх болон гүтгэлэг хамт байх тохиолдолд нөхөн төлбөрийн хэмжээ өндөр.
Эд хөрөнгийн зөрчил		2		4000	250	
Бусад зөрчил		2		500		

БНСУ-ын шүүхийн хууль эрх зүйн цогц мэдээллийн сангаас гаргасан тайланг үндэслэвэл сүүлийн 4 жилд (2012-2015 он) хүний амь насыг хохироосноос сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийн дээд хэмжээ 56 сая вон, дундаж нь 20-30 сая вонын хооронд

⁴¹ Мөн тэнд. Эшлэл 13. 58-59 дэх тал.

⁴² Чой Хён Шик. Хууль бус үйлдлийн улмаас сэтгэцэд учирсан хохирлын нөхөн төлбөрийн тухай судалгаа /докторын ажил/. 2016 он. 99-100 дахь тал.
http://gachon.dcollection.net/public_resource/pdf/000002237005_20230327103351.pdf. (Сүүлд үзсэн: 2023.03.27).

байна. Бэлгийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд гэмт хэргийн зэрэг болон давтамжаас хамааран 20-50 сая воны хооронд, бэлгийн дарамт үзүүлсэн тохиолдолд 10 саяас эхлэн зэргээсээ хамааран олгогддог байна. Эхнэр, нөхөр хамтрагчаа хууран мэхэлсэн тохиолдолд ерөнхийдөө 20-30 сая воны хооронд, эмнэлгийн хайхрамжгүй байдал буюу алдаа гаргасан тохиолдолд стандарт нь 60 сая вон, эмнэлэг тайлбарлах үүргээ биелүүлээгүй тохиолдолд стандарт нь 20-30 сая воны хооронд байх ба өвчтөний хөдөлмөрийн чадвараа алдсан болон хайхрамжгүй хандсан зэргийг харгалзан нөхөн төлбөрийн хэмжээг тогтоодог.⁴³

БНСУ-ын Дээд шүүхээс 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр зөвхөн шүүгч нарын нөхөн төлбөрийн хэмжээг тооцохдоо ашигладаг байсан программыг⁴⁴ олон нийтэд нээлттэй болгосноор хүн бүр нарийн төвөгтэй нөхөн төлбөрийн хэмжээг хялбар аргаар тооцох, нэхэмжлэл гаргахдаа түүнийг ашиглах боломжтой болсон. Энэхүү программын тусламжтай зам тээврийн осол, үйлдвэрийн ослын улмаас учирсан хохирлын нөхөн төлбөр, өв залгамжлал, хүү тооцох зэрэг асуудлыг хөнгөвчилсэн байна. Өөрийн төрсөн он сар өдөр, ослын төрөл, осол болсон өдөр зэрэг энгийн мэдээлэл оруулахад уг программ нь таны нас, цаашид амьдрах хугацааг тооцоод хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, жилийн цалингийн нэгж үнийг автоматаар тусгаж, олох ёстой байсан орлогыг үе тус бүрээр тооцож гаргаж ирдэг.⁴⁵ Гэвч энэхүү программ нь сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийн хэмжээг тооцох боломжгүй юм.

Эндээс БНСУ-д сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийн тогтсон хэмжээ, стандарт байдаггүйг харж байна. Судалгааны ажил, ном, сурах бичгээс харвал нөхөн төлбөрийн дээд, доод хэмжээг зөвхөн шүүхийн практик, шүүхийн шийдвэрүүдэд хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан тооцсон нь харагдаж байна.

2.3. Бүгд Найрамдах Сингапур Улс

Сингапур Улсад гэмт хэргийн хохирогчдод төрөөс санхүүжүүлдэг нөхөн олговор олгох тогтолцоо байдаггүй. Харин 2018 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 359 дүгээр зүйлд⁴⁶ орсон нэмэлтийн дагуу эрүүгийн хэргийн шүүх шүүгдэгчээс хохирогчид нөхөн төлбөр олгуулах захирамж гаргах боломжтой болсон. Энэ тохиолдолд нөхөн төлбөрийн хэмжээг шүүхээс тогтоох бөгөөд иргэний журмаар нэхэмжилж болох хэмжээнээс хэтрүүлж болохгүй. Уг нэмэлттэй холбоотойгоор тус улсын дээд шүүхээс 2018 онд шийдвэрлэсэн Тэй Ви Киат⁴⁷ -д холбогдох хэрэгт гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлөхийн ач холбогдол болоод нөхөн төлбөрийг тодорхойлоход бодит болоод үндэслэл бүхий нөхцөлд суурилж тогтоох үндсэн баримжааг тодорхойлжээ.

Сэтгэл санааны хохирлыг хүлээн зөвшөөрсөн материаллаг хуулийн зохицуулалт, түүний агуулгыг шүүхийн жишгээр тогтоосон. 1871 оны Эрүүгийн хуулийн 319 дүгээр зүйлд “Биеийн өвдөлт, өвчин, бие эрхтний гажиг үүсгэсэн тохиолдолд бусдын биед гэмтэл учруулсан гэж үзнэ” хэмээн заасны дагуу сэтгэл санааны хохирол нь биед учруулсан гэмтлийн нэгд тооцогдоно.⁴⁸

Сингапур улсын шүүх нь аливаа учирсан хохирлыг нөхөн төлж барагдуулах талаар шийдвэр гаргахдаа “Хувь хүнд гэмтэл учруулсан хэргийн ерөнхий хохирлыг үнэлэх удирдамж”⁴⁹ -ийг /цаашид “Удирдамж” гэх/ баримталдаг. Энэхүү Удирдамжийг Сингапур

⁴³ Мөн тэнд. Эшлэл 16. 100 дахь тал.

⁴⁴ <http://ejpc.scourt.go.kr/>, (Сүүлд үзсэн: 2023.03.27).

⁴⁵ <https://www.legaltimes.co.kr/news/articleView.html?idxno=43839>, (Сүүлд үзсэн: 2023.03.27).

⁴⁶ Сингапур улсын Эрүүгийн процессын хууль (*Criminal Procedure Code*), 2010, section 359.

⁴⁷ *Tay Wee Kiat and Another v Public Prosecutor* [2018] SGHC 114 at [19].

⁴⁸ *Public Prosecutor v Kwong Kok Hing* [2008] 2 SLR(R) 684 at [26]-[28].

⁴⁹ *Guidelines for the Assessment of General Damages in Personal Injury Cases*.

улсын шүүхүүд, тус улсын Хуулийн академитай хамтран боловсруулсан. Үүнд аливаа хувь хүнд учрах гэмтэл, хохирлыг хэрхэн, хэр хэмжээнд нөхөн төлж барагдуулах тухай дэлгэрэнгүй зааж өгсөн байдаг. Хэрэв уг Удирдамжид тусгагдаагүй гэмтэл, хохирол учирсан хэрэг гарвал Их Британи улсын “Хувь хүнд гэмтэл учруулсан хэргийн ерөнхий хохирлыг үнэлэх удирдамж”-ийг зааварчилгаа болгон ашиглаж мөн улсын ижил төстэй өмнөх хэргүүдийн шийдвэрүүдийг жишиг болгон хэрэглэдэг байна.⁵⁰

Удирдамж нь бүртгэгдсэн хэрэг, тохиолдлуудаас дүгнэн гаргаж авсан хохирлын жагсаалтыг агуулах бөгөөд тодорхой гэмтлийн нөхөн төлбөрийн боломжит хүрээг зааж өгсөн болно. Энэхүү удирдамжид гэмтлийн зэрэглэлийг ангилж өгсөн байдаг хэдий ч хувь хүний онцлогоос хамаараад хүн бүрд өөр өөр үр дагавартай байх тохиолдолд байдаг. Ихэнх тохиолдолд Удирдамжийг ашиглахдаа эхлээд гэмтлийн төрлийг тодорхойлно. Ингэхдээ хамгийн их гэмтэл авсан биеийн хэсгийг тодорхойлдог. Жишээлбэл: толгой, сэтгэцэд учирсан хор уршиг, мэдрэхүйд учирсан гэмтэл, дотор эрхтний гэмтэл, ортопедийн гэмтэл буюу үе мөч, яс, бие махбодын гэмтэл, нүүрний гэмтэл, үсний гэмтэл, арьсны гэмтэл гэх зэрэг орно.

Үүний дараагаар гэмтлийн зэрэглэлийг тодорхойлно. Ингэхдээ уг гэмтэл хохирогчийн амьдралын хэв маягт хэрхэн сөргөөр нөлөөлөх, өвдөлтийн хэмжээ болон үүсгэсэн нөхцөл байдлын хэр удаан үргэлжлэх зэргийг авч үзэн ерөнхийд нь хүнд, хүндэвтэр, дунд зэрэг, хөнгөн гэж 4 ангилдаг. Дараагийн шатанд нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлно. Ихэнх тохиолдолд тодорхой үнэлгээний хязгаартай байх боловч хэрэг тус бүрийг тусгайлан авч үзэх шаардлагатай байдаг. Эцэст нь бусад давхар учирсан хохирлуудыг авч хэлэлцдэг байна.⁵¹

Уг Удирдамжид бие махбодын гэмтэл болон сэтгэцэд учирсан хор уршигийг арилгах, нөхөн төлүүлэх тухай тусгасан байдаг бөгөөд энэхүү судалгааны хамрах хүрээнд зөвхөн сэтгэцэд учирсан хор уршигийг арилгах, нөхөн төлүүлэх талаар оруулсан болно.

1.1. Сэтгэцийн ерөнхий гэмтэл

Сэтгэлийн хямрал, зайлсхийх фоби, айдас түгшүүрийн дайралт гэх мэт гэмт явдлын үр дүнд үүсэж болох олон тооны сэтгэцийн эмгэгүүд байдаг. Эдгээр нь дотроо зэрэглэлд хуваагдсан байдаг. Хамгийн хүнд хэлбэрийн сэтгэцийн эмгэгүүд нь хүнийг өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг хэвийн явуулж, даван туулах чадваргүй болгоход хүртэл хүргэж болно. Ийм төрлийн нэхэмжлэлийг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ:

- 1) Гэмтлийн өмнөх үеийнхтэй харьцуулахад тухайн хүний амьдрал, ажлыг ерөнхийд нь даван туулах чадвар;
- 2) Тухайн хүний гэр бүл, найз нөхөд, бусад хүмүүстэй харилцах харилцаанд үзүүлэх нөлөө;
- 3) Тухайн хүн сэтгэцийн эмгэгийн улмаас амиа хорлох шинжтэй болсон эсэх;
- 4) Эмнэлгийн тусламж хүссэн эсэх;
- 5) Эмчилгээ хэр зэрэг амжилттай болох;
- 6) Эмчилгээ нь тухайн хүний ажил, нийгмийн амьдралд хэр зэрэг нөлөөлөх;
- 7) Тухайн хүн эмчилгээг хэр үнэнчээр дагаж, эмээ ууж байгаа эсэх;
- 8) Ирээдүйд эмгэг нь дахилт үүсэж, сэдрэх эрсдэл;
- 9) Ирээдүйд бүрэн эдгэрэх боломж.

⁵⁰ Justice Without Borders, *Strategy Guide*. p. 11.

⁵¹ Justice Without Borders, *Strategy Guide*. p. 26.

Гэмтлийн зэрэглэл	Ангиллын тайлбар	Хохирол (Синг. Доллар)
Хүнд	Тухайн хүн дээр дурдсан 1-ээс 6 хүртэлх заасан хүчин зүйлсийн хувьд хурц асуудалтай байна. Хэдийгээр эмчилгээ хийлгэж байгаа ч өвчний цаашдын явцыг урьдчилан дүгнэх боломж /цаашид прогноз гэх/ маш муу бөгөөд тухайн хүн ажилдаа эргэн хэвийн орох болон өдөр тутмын энгийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжгүй.	\$25,000– \$55,000
Хүндэвтэр	Дээрх 1-ээс 6 хүртэлх заасан хүчин зүйлсийн хувьд мэдэгдэхүйц асуудалтай байх боловч “Хүнд” зэрэглэлтэй харьцуулахад өвчний цаашдын явцыг урьдчилан дүгнэх боломжтой байх болно. Гэсэн хэдий ч тухайн хүн ажил, амьдралын стресс, нийгмийн амьдралын эрэлт хэрэгцээг даван туулахад удаан хугацааны бэрхшээлтэй хэвээр байх тул гэмтлээс өмнөх үе шигээ ажилдаа эргэн хэвийн орохоос сэргийлж болно. Харин тухайн хүн өдөр тутмын амьдралынхаа үйл ажиллагааг бие даан хэвийн хийх чадвартай байна.	\$8,000– \$25,000
Дунд зэрэг	Тухайн хүн дээрх 1-ээс 6 хүртэлх заасан хүчин зүйлсийн хувьд асуудалтай байх болно. Харин эмчилгээний үр дүн сайн байх бөгөөд өвчний прогноз эерэг, сайн байх болно.	\$3,000– \$8,000
Хөнгөн	Богино хугацаанд бүрэн эдгэрэх бөгөөд цаашид дахин сэдэрэх эрсдэл бага байна. Тухайн хүн өмнөх ажилдаа бага зэргийн эсхүл огт хүндрэлгүйгээр эргэн хэвийн орох боломжтой. Энэ түвшний нөхөн төлбөрийг тооцохдоо богино хугацаанд үргэлжилсэн хүндрэл, өдөр тутмын үйл ажиллагаа болон нойронд хэр зэрэг нөлөөлсөн зэргийг харгалзан үздэг.	\$1,000– \$3,000

1.2. Гэмтлийн дараах стрессийн эмгэг⁵² /цаашид “ГДСЭ” гэх/

Удирдамжид ГДСЭ нь гэмт явдалд өртсөний дараа үүсдэг хүнд хэлбэрийн түгшүүрийн эмгэг гэж тодорхойлсон. Оношилгооны албан ёсны шалгууруудад зааснаар (DSM-IV ба ICD-9) шинж тэмдгүүдийг нэг сараас илүү үргэлжлэхийг шаарддаг бөгөөд хүний амьдралын бүх талбарт мэдэгдэхүйц доройтол үүсгэнэ. ГДСЭ-ийн зарим шинж тэмдгүүдэд давтагдах дурсамжууд, байнгын хар дарсан зүүд, зайлсхийх болон хэт мэдрэмтгий болох зэргийг оруулдаг.

Гэмтлийн зэрэглэл	Ангиллын тайлбар	Хохирол (Синг. Доллар)
Хүнд	Тухайн хүн хүнд хэлбэрийн ГДСЭ-ээр өвчилсөн тохиолдолд сул доройтол, тамирдалтад өртдөг. Тэрээр өдөр тутмын амьдралаа давтагдах дурсамжуудаас болж даван туулж чаддаггүй бөгөөд эмчилгээ хийлгэсэн ч стресстэй, ууртай, хэт мэдрэмтгий болдог. Үүний үр дүнд тухайн хүн ажил эрхэлж чадахгүйд хүрдэг. Өвчний прогноз маш муу, шинж тэмдгүүд нь удаан хугацаанд үргэлжлэх магадлалтай.	\$25,000– \$50,000
Хүндэвтэр	Энэ ангилал нь өвчний прогноз илүү сайн байх тул "Хүнд" ангиллаас ялгаатай. Гэсэн хэдий ч үр дагавар нь ойрын ирээдүйд мэдэгдэхүйц хэмжээний асуудлууд үүсгэх магадлалтай хэвээр байх бөгөөд тухайн хүн ажилдаа гэмтлийн өмнөх шигээ хэвийн эргэн орох магадлал бага байдаг.	\$10,000– \$25,000
Дунд зэрэг	Дунд зэргийн хэлбэрийн үед эдгэрэлт нь харьцангуй сайн. Хэдийгээр шинж тэмдгүүд нь удаан хугацаанд үргэлжилсээр байгаа ч тухайн хүн өдөр тутмын амьдралын шаардлагыг даван туулах чадвартай байх бөгөөд цаашдаа ажил, мэргэжил эрхлэх боломжтой. Гэсэн хэдий ч тэрээр гэмтлийн өмнөх үе шигээ ажил, мэргэжлийнхээ шаардлагыг даван туулж	\$4,000– \$10,000

⁵² Post-Traumatic Stress Disorder (PTSD).

	чадахгүй бөгөөд зөвхөн стресс багатай ажил хийх чадвартай болж болзошгүй.	
Хөнгөн	Бүрэн эдгэрэлт нь нэг эсвэл хоёр жилийн дотор явагдах бөгөөд бага зэргийн шинж тэмдгүүд хэвээр үлддэг. Өвчний прогноз маш сайн байна.	\$2,000– \$4,000

1.3. Архаг өвдөлтийн хам шинж

Энэ эмгэг нь ихэвчлэн цочмог өвдөлтийг мэдэрсний дараа үүсдэг. Архаг өвдөлтийн хам шинж нь гэмтсэн эд, булчин, ясыг нөхөн сэргээн эмчлэгдэх боломжит хугацаанаас илүү удаан үргэлжилдэг өвдөлт гэж тодорхойлогддог. Энэ нь ихэвчлэн гурван сараас дээш хугацаанд үргэлжилдэг. Удаан давтагдах тэрхүү өвдөлт нь бие махбодын төдийгүй сэтгэцийн хор уршиг үүсгэдэг. Нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлохдоо дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай:

- 1) Өвдөлтийн хэмжээ;
- 2) Өвдөлтийн үргэлжлэх хугацаа болон байнгын байдал;
- 3) Архаг өвдөлтийн үр дүнд үүсэх хүндрэл, сөрөг үр нөлөө;
- 4) Өвдөлтийг хянах эмчилгээ, сэтгэцийн зан байдлын эмчилгээний үр дүнтэй байдал.

Гэмтлийн зэрэглэл	Ангиллын тайлбар	Хохирол (Синг. Доллар)
Хүнд	Удирдамжид тайлбар өгөөгүй.	\$20,000 – \$35,000
Хүндэвтэр		\$10,000 – \$20,000
Дунд зэрэг		\$5,000 – \$10,000

1.4. Рефлексийн симпатик дистрофи

Энэ бол хүнд хэлбэрийн өвдөлт, хавагнал, арьсны өөрчлөлтөөр тодорхойлогддог архаг явцтай өвчин юм. Үе мөчийг эсвэл өвчинд нэрвэгдсэн хэсгийг хөдөлгөх эсвэл хүрэхэд ихэвчлэн тэвчихийн аргагүй өвдөлтийг үүсгэдэг бөгөөд энэ өвдөлт нь сэтгэлийн дарамтаас болж нэмэгддэг. Үүний үр дүнд тухайн хүний гэмтсэн үе мөчийг удаан хөдөлгөөнгүй байлгаснаас арьс, булчин, ясны хатангиршил үүсдэг. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн өвчлөл нь сэтгэл санааны дарамтыг давхар бий болгодог байна. Хөнгөн хэлбэрийн үед хүн удаан хугацааны хүндрэл, бэрхшээлгүйгээр хэдхэн сарын дотор аяндаа эдгэрдэг байна.

Гэмтлийн зэрэглэл	Ангиллын тайлбар	Хохирол (Синг. Доллар)
Хүнд	Удирдамжид тайлбар өгөөгүй.	\$25,000 – \$50,000
Хүндэвтэр		\$12,000 – \$25,000
Дунд зэрэг		\$5,000 – \$12,000

1.5. Соматоформын эмгэг

Энэ нь бие махбодын өвчин, гэмтэлтэй адил хэлбэрээр илэрдэг бөгөөд тодорхой шалтгаангүй бие махбодын шинж тэмдгээр мөн илэрдэг сэтгэцийн эмгэг юм. Удирдамжид энэ төрлийн хохирлын нөхөн төлбөр нь 22,000 Сингапур доллар байх ёстой гэж заасан байдаг.⁵³

2.4. Оросын Холбооны Улс

ОХУ-д энэхүү судалгааны хүрээнд тулгамдаж буй голлох асуудлуудад хариулт өгөх замаар энэхүү бүлэгт авч үзэх болно.

⁵³ Justice Without Borders, Simmons & Simmons JWS. (2019). *Strategy Guide on Measuring Damages for Injuries Suffered by Migrant Workers*. Strategic Legal Research Series. p. 26-29.

1. ОХУ-д гэмт хэргийн улмаас учирсан болон аливаа сэтгэл санааны хохирлыг үнийн дүнгээр тооцох аргачлал бий эсэх

Шүүхээс сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн үнийн дүнгийн хэмжээг тогтоох асуудал нь үнэлэх шинж чанартай буюу одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид аливаа үнийн дүнг тогтоох тодорхой шалгуур байхгүй. Зарчмын хувьд шүүгчид өөрсдөд нь хуулиар олгогдсон өөрийн итгэл үнэмшлээрээ хэргийг шийдвэрлэх эрхийнхээ хүрээнд сэтгэл санааны нөхөн төлбөрийн үнийн дүнг тодорхойлж шийдвэр гаргадаг.⁵⁴

Одоогийн байдлаар сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ, үнийн дүнг тогтоох буюу тодорхойлоход шүүхээс баримтлах сэтгэл санааны нөхөн төлбөрийн үнийн дүнг тооцох тогтсон аргачлал болон тогтоосон хэмжээ байхгүй.⁵⁵

2. ОХУ-д сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх үнийн дүнгийн дээд, доод хэмжээ бий эсэх

ОХУ-д сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх дээд, доод хэмжээг хуульд болон бусад албан ёсны баримт бичигт тусгаагүй байна. Учир нь Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар баталсан 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн № 33 дугаартай “Шүүхээс сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх тухай хэм хэмжээг хэрэглэсэн практикийн тухай” тогтоолын “Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх арга болон хэмжээ” гэсэн 3-р бүлэгт нь нөхөн төлбөрийн хэмжээний дээд, доод үнийг тогтоох талаар ямар нэгэн зүйл дурдаагүй.⁵⁶

Иргэдийн амь нас болон эрүүл мэндэд халдсантай холбоотой сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох зохицуулалтыг журамлахтай холбоотой Холбооны Зөвлөлийн 2020 онд болсон дугуй ширээний уулзалт дээр Шүүгчдийн зөвлөлийн тэргүүн Виктор Момотов: “хууль тогтоомжоор сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн үнийн дүнгийн дээд болон доод хэмжээг тогтоох нь сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн өөр хэмжээг нэмэлт үндэслэл болгон хуулиар тогтоогоогүй дүнг нэхэмжлэх шаардлага тулгарсан хохирогч талын байдалд сөргөөр нөлөөлнө” хэмээн байр сууриа илэрхийлжээ. Тодруулбал сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн үнийн дүнгийн дээд болон доод хэмжээг тогтоох нь иргэдийн нөхцөл байдлыг улам дордуулж, хүний эрх болон эрх чөлөөг хамгаалах баталгааг нэмэгдүүлэх зорилгод нийцэхгүй. Одоо үед сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо шүүх зөвхөн хууль тогтоомж, шударга ёсны болон үндэслэлтэй байх шалгууруудаас гадна хохирогчийн өөрийнхөө амссан зовлонг үнэлж буй байдлыг нь харгалзан үздэг нь нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох хангалттай үндэслэл болно” гэв.⁵⁷

Хохирогчийн өөрийнхөө амссан зовлонг үнэлсэн байдал гэдэгт хохирогч сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлдээ дурдаж хариуцагчаас нэхэмжилсэн үнийн дүнг ойлгоно.

3. ОХУ-д сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх талаар дээд шүүхийн зөвлөмж бий эсэх

⁵⁴ Определение Конституционного Суда РФ от 15 июля 2004 г. № 276-О// (ОХУ-ын Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 7-р сарын 15-ны өдрийн № 276-О тогтоол), <https://base.garant.ru/1777674/> (Сүүлд үзсэн: 2023.03.15).

⁵⁵ Официальный сайт Администрации Борисовского муниципального образования Тайшетского района Иркутской области// (Эрхүү мужийн Тайшет дүүргийн Борисовск засаг захиргааны нэгжийн албан ёсны цахим хуудас) <https://xn----8sbbemu6akbbsn.xn--p1ai/vzyskanie-vozmeshhenija-moralnogo-vreda/>, (Сүүлд үзсэн: 2023.03.15).

⁵⁶ Официальный сайт органа Федеральной палаты адвокатов РФ ОХУ-ын Холбооны Өмгөөлөгчдийн танхимын албан ёсны цахим хуудас <https://www.advgazeta.ru/diskussii/stoimost-chelovecheskoy-zhizni/>, (Сүүлд үзсэн: 2023.03.15).

⁵⁷ Момотов: формула компенсации морального вреда не может быть универсальной//Момотов: Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх томъёо нь төгс байж чадахгүй, <https://pravo.ru/news/227095/> (Сүүлд үзсэн: 2023.03.15).

ОХУ-ын Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн № 33 дугаартай “Шүүхүүдийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх тухай хэм хэмжээг хэрэглэсэн практикийн тухай” тогтоол бий бөгөөд орчуулгыг судалгаанд хавсаргасан болно.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Сэтгэл санааны хохирол, сэтгэцийн хор уршиг гэх нэр томъёоны хууль зүйн агуулгыг илрүүлэх, цаашлаад сэтгэл санаа эсхүл сэтгэцэд учирсан хор уршигийг нөхөн төлүүлэхэд хэрэглэгддэг жишиг аргачлалыг судлах хүрээнд онол, практикийн өргөн хэмжээний судалгааг гүйцэтгэсний эцэст дараах үр дүн ажиглагдаж байна.

Манай Улсын хувьд Иргэний хэргийн шүүхээс сэтгэл санааны хохирол болон сэтгэцэд учирсан хор уршиг гэх ойлголтыг бодит хэргийг шийдвэрлэхдээ тодорхойлсон тохиолдол хараахан илэрсэнгүй (2017.01.01 – одоог хүртэл). Мөн дотоодын эрдэмтэн судлаачдын зохиол бүтээлд хангалттай тодорхойлсон зүйл алга байна.

Харьцуулсан судалгааны үр дүнг харгалзан тодорхойлбол “сэтгэл санааны хохирол гэдэг” нь нэгдүгээр бүлэгт дурдсан сэтгэцэд учирсан хор уршигийн өргөн болон явцуу утгын аль алиныг илэрхийлэх боломжтой албан бус, онолын нэр томъёо юм. “Сэтгэцэд учирсан гэм хор” болон “сэтгэцэд учирсан хор уршиг” гэх ойлголтууд нь агуулгын хувьд ялгаагүй бөгөөд сэтгэцэд учирсан хор уршигийн өргөн болон явцуу утгын нийлбэр гэж ойлгох нь зүйтэй байна. Гэвч харьцуулсан судалгааны үр дүнг харахад өргөн утгыг илүүтэй илэрхийлж байж болзошгүй. Сэтгэцэд учирсан гэм хорын суурь нь Иргэний эрх зүйн гэм хорын тогтолцоо бөгөөд Иргэний эрх зүйн гэм хорын нэг төрөл байдлаар томъёологдсон байна (ИХ-ийн 230.2). Энэхүү онолын нэршлийг хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Иргэний хууль болон бусад хуулиудад Сэтгэцэд учирсан хор уршиг гэх нэр томъёогоор илэрхийлэх болжээ.

Гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршиг гэх ойлголтын хувьд илүү объектив, бодитой байдаг гэх утгаар “сэтгэцэд учирсан хор уршигийн” өргөн утгад илүү хамааралтай мэт боловч, гэмт хэргээс улбаалан шууд гэмтэл аваагүй ч сэтгэцийн хохирол амсах тохиолдлуудыг үгүйсгэх боломжгүй тул “сэтгэцэд учрах хор уршигийн” явцуу утгыг ч мөн харгалзах нь зүйтэй.

Сэтгэцэд учирсан хор уршигийг нөхөн төлүүлэх аргачлалтай холбоотой зохицуулалтын хүрээнд хийсэн харьцуулсан судалгааны үр дүнгээс харвал нэн тэргүүнд цохон тэмдэглэх ёстой зүйл нь аль ч улсад уг аргачлал, түүгээр тогтоосон жишгийг заавал дагаж мөрдөх албагүй буюу энэ нь императив хэм хэмжээ биш байна. Мөн ийм төрлийн аргачлалыг боловсруулах, батлах чиг үүргийг төрийн байгууллага хүлээдэггүй бөгөөд илүү хувийн хэвшлийн мэргэжилтнүүд шүүхийн жишгийг судлах замаар боловсруулдаг болох нь ажиглагдлаа. Энэ нь энэ салбарын хөгжил нь зогсолтгүй, чөлөөтэй, өрсөлдөөнтэй байх ёстой гэсэн үзэл баримтлалтай холбоотой байна.

ЭХ СУРВАЛЖ

- А.Түвшинтөгс, Д.Ганхүрэл, Э.Золзаяа, “Сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх нэхэмжлэлтэй хэргийн хянан шийдвэрлэж буй шүүхийн практик, харьцуулсан дүн шинжилгээ”, ННФ Шүүхийн Шийдвэрийн Судалгаа №4, 15 тал (2022 он).
- Б.Ариунзаяа, Л.Амгаланбаатар, Х.Норовсүрэн, “Эдийн бус хохирол нөхөн төлүүлэх тогтолцооны талаарх онолын асуудал ба Монгол Улсын шүүхээр эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж буй байдал”, ННФ Шүүхийн Шийдвэрийн Судалгаа №4, 94 тал (2022 он).
- Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн, “Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцох аргачлал, гадаадын зарим улсын туршлага /Харьцуулсан судалгаа/, Судалгааны тайлан, (2021 он).
- П.Сайнзориг, “Сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлүүлэх эрх зүйн шийдэл /Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөл/, Эдийн бус хохирол ба сэтгэл санааны хохирол хэлэлцүүлэг, (2022 он).
- Cees Van Dam, EUROPEAN TORT LAW (OUP 2d ed. 2013).
- Giovanni Comandè, *Towards a Global Model for Adjudicating Personal Injury Damages: Bridging Europe and the United States*, 19(2) TEMPLE INT'L & COMP. L. J. 241 (2006).
- Ronen Avraham, *Estimating Pain and Suffering Damages*, in THE OXFORD HANDBOOK OF LAW AND ECONOMICS: VOLUME 2: PRIVATE AND COMMERCIAL LAW 97 (Francesco Parisi eds., 2017).
- Stephen D. Sugarman, *Tort Damages for Non-economic losses*, in COMPARATIVE TORT LAW 201 (M.Bussani & A. Sebok eds., 2013)
- Ulrich Magnus, *Damages for Non-economic loss: German Developments in a Comparative Perspective*, 39(3) INT'L & COMP. LAW Q. 675 (1990);
- Vernon Valentine Palmer, *Moral Damages: The French Awakening in the Nineteenth Century*, 36 Tul. Eur. & Civ. L. F. 45 (2021).
- 斎藤修「慰謝料の現代的課題」私法 74号 156頁 (2012年)。
- 斎藤修「総論」斎藤修編『慰謝料算定の理論』(ぎょうせい 2010年)。
- 住田守道「我が国の慰謝料論の軌跡と課題：人身損害賠償を中心に」大阪市立大学法学雑誌 66巻 1-2号 168頁 (2020年)。
- 法務大臣官房司法法制調査部監修『法典調査会民法議事速記録五(日本近代立法資料叢書 5)』(商事法務研究会 1984年)。
- 我妻榮『事務管理・不当利得・不法行為』(日本評論社 1937 [復刻：1988])。
- 藤村和夫「交通事故」斎藤修編『慰謝料算定の理論』33頁参照(ぎょうせい 2010年)。
- 住田守道「人損慰謝料算定の諸問題と算定プロセス論」大阪府立大学経済研究 66巻 3・4号 17頁 2021年)。
- 日弁連交通事故相談センター『交通事故損害賠償額算定基準—実務運用と解説』(平成 20年)。
- БНСУ-ын Иргэний хууль (2022)
<https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EB%AF%BC%EB%B2%95/%EC%A0%9C751%EC%A1%B0>
- Солонгосын хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэн. Англи Солонгос Монгол Хууль зүйн толь. 2010 он.
<https://www.klri.re.kr/kor/publication/922/view.do>
- 국어 대사전 (ㄱ~ㄴ). 1996.
- 국어 대사전 (ㅇ~ㅎ). 1999.

- 법제처. 법령용어한영사전. 2008.
https://www.moleg.go.kr/viewer/skin/doc.html?fn=0010_43927_1&rs=/viewer/result/202303
- 김상용. 불법행위법. 1997.
- 주현준. 불법행위로 인한 정신적 손해배상책임에 관한 연구 /석사 학위논문/. 2019.
https://dcollection.pusan.ac.kr/public_resource/pdf/000000141402_20230327095032.pdf
- 최현식. 불법행위로 인한 정신적 손해배상에 대한 연구/박사 학위논문/. 2016.
http://gachon.dcollection.net/public_resource/pdf/000002237005_20230327103351.pdf
- Justice Without Borders, Simmons & Simmons JWS. (2019). *Strategy Guide on Measuring Damages for Injuries Suffered by Migrant Workers*. Strategic Legal Research Series. Цахим холбоос: <https://forjusticewithoutborders.org/wp-content/uploads/2019/03/Strategy-Guide-for-Measuring-Damages-for-Injuries-Suffered-by-Migrant-Workers-in-Singapore.pdf>
- Гражданский кодекс Российской Федерации часть 2 (ГК РФ ч.2) от 26 января 1996 года N 14-ФЗ// (ОХУ-ын Иргэний хуулийн 2-р хэсэг (ОХУ-ын Иргэний хуулийн 2-р хэсэг) 1996 оны 1-р сарын 26-ны N 14) URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_9027/
- "Гражданский процессуальный кодекс Российской Федерации" от 14.11.2002 N 138-ФЗ// (ОХУ-ын 2002 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн № 138 “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”) URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570/
- Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ// (2001.12.18 № 174 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль) URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/
- Постановление Пленума Верховного Суда РФ от 13.10.2020 N 23 "О практике рассмотрения судами гражданского иска по уголовному делу"// (ОХУ-ын Дээд Шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2020 оны 10-р сарын 13-ны өдрийн №23 “Эрүүгийн хэрэг дэх иргэний нэхэмжлэлийг шүүхээр хянан хэлэлцэх практикийн тухай” тогтоол) URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_365020/
- Постановление Пленума Верховного Суда РФ от 15.11.2022 N 33 "О практике применения судами норм о компенсации морального вреда"// (Оросын Холбооны Улсын Улсын Дээд Шүүхийн Нийт Шүүгчдийн хуралдааны 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн № 33 “Шүүхүүдийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх тухай хэм хэмжээг хэрэглэсэн практикийн тухай” тогтоол) URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_431485/c3ae0e20f7f4bbbcd4796614b570b71c93f54d5e/#dst100058
- Определение Конституционного Суда РФ от 15 июля 2004 г. № 276-О// (ОХУ-ын Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 7-р сарын 15-ны өдрийн № 276-О тогтоол). URL: <https://base.garant.ru/1777674/>
- А. С. Бергман. П. М. Ярошевский. Ф. Н. Голдберг. П. С. Александров. Подготовка электронной публикации и общая редакция: Центр гуманитарных технологий. Ответственный редактор: А. В. Агеев.// (Цахим хэвлэл бэлтгэх болон ерөнхий редакци: Хүмүүнлэгийн технологийн төв. Хариуцсан редактор. А.В.Агеев.) URL: <https://gtmarket.ru/concepts/7131>
- Большой юридический словарь.// Том хуулийн толь бичиг URL: 2. <http://www.gufo.me/dict/law#>
- Мартыненко Н. Э. Понятия «Вред» и «Ущерб» и их уголовно-правовая оценка // Труды Академии управления МВД России. 2020. № 2 (54) // (Гэм хор (хохирол) болон хор уршиг (хор хөнөөл) болон тэдгээрийн эрүүгийн эрх зүйн үнэлгээ // ОХУ-ын Дотоод хэргийн яамны Удирдлагын академийн эмхтгэл. 2020. № 2 (54)) URL: <https://cyberleninka.ru/article/n/ponyatiya-vred-i-uscherb-i-ih-ugolovno-pravovaya-otsenka#:~:text=%D0%92%20%D1%8E%D1%80%D0%B8%D0%B4%D0%B8%D1%87%D0%B5%D1%81%D0%BA%D0%BE%D0%BC%20%D1%81%D0%BB%D0%BE%D0%B2%D0%B0%D1%80%D0%B5%20%D0%B2%D1%80%D0%B5%D0%B4%20%D0%BE%D0%BF>

[%D1%80%D0%B5%D0%B4%D0%B5%D0%BB%D1%8F%D0%B5%D1%82%D1%81%D1%8F,%D0%BC%D0%BE%D1%80%D0%B0%D0%BB%D1%8C%D0%BD%D1%8B%D0%B9%20%D0%B2%D1%80%D0%B5%D0%B4](#)

- Момотов: формула компенсации морального вреда не может быть универсальной//Момотов: Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх томъёо нь төгс байж чадахгүй.URL: <https://pravo.ru/news/227095/>
- Мораль// Ёс суртахуун (сэтгэл санаа) URL: <https://foxford.ru/wiki/obschestvoznanie/moral>
- Этимология и генезис терминов «этика», «мораль», «нравственность»// ("Этика", "ёс суртахуун", "сэтгэл санаа" гэсэн нэр томъёоны гарал үүсэл) URL: <http://www.abccba.ru/abc16.php>
- Официальный сайт Администрации Борисовского муниципального образования Тайшетского района Иркутской области// (Эрхүү мужийн Тайшет дүүргийн Борисовск засаг захиргааны нэгжийн албан ёсны цахим хуудас) URL: <https://xn---8sbbemu6akbbsn.xn--p1ai/vzyskanie-vozmeshhenija-moralnogo-vreda/>
- Официальный сайт органа Федеральной палаты адвокатов РФ ОХУ-ын Холбооны Өмгөөлөгчдийн танхимын албан ёсны цахим хуудас. URL: <https://www.advgazeta.ru/diskussii/stoimost-chelovecheskoy-zhizni/>